



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ  
ЭКОНОМИКСИЙН ТЭНХИМ

Тайж  
Доржпаламын ДОРЖДЭРЭМ

МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН  
ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨГ АХИУЛАХ  
БОЛОМЖИЙН СУДАЛГАА



Мэргэжлийн индекс  
031101

Эдийн засгийн ухааны бакалаврын  
зэрэг горилсон  
Дипломын төсөл

Удирдсан  
Д.Түвшинжаргал /Ph.D/

Улаанбаатар. 2024



**САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭКОНОМИКСИЙН ТЭНХИМ**

**Тайж**  
**Доржпаламын Дорждэрэм**

**МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН**  
**ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨГ АХИУЛАХ**  
**БОЛОМЖИЙН СУДАЛГАА**

**В** Мэргэжлийн индекс  
031101

**Эдийн Засгийн Ухааны Бакалаврын Зэрэг**  
**Горилсон Дипломын Төсөл**

Удирдагч: ..... Д.Түвшинжаргал /Ph.D/

Шүүмжлэгч: ..... П.Гантөмөр /Ph.D/

Улаанбаатар. 2024

**ГАРЧГИЙН ТОВЬЁГ**

МЭДЭГДЭЛ .....	iii
ТАЛАРХАЛ.....	iv
ТОВЧ ХУРААНГУЙ.....	v
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ .....	vi
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ .....	vii
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ .....	viii
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	ix
ОРШИЛ .....	1
I БҮЛЭГ. НОМ ЗҮЙН ТОЙМ БУЮУ СУДЛАГДСАН БАЙДАЛ.....	3
1.1 Онолын судлагдсан байдлын тойм .....	3
1.1.1 Бичил санхүү.....	3
1.1.2 Санхүүгийн институт.....	4
1.1.3 Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төрийн оролцооны үзэл баримтлалууд .....	6
1.2 Эмпирик судалгааны судлагдсан байдлын тойм .....	10
1.2.1 ЖДҮ-ийн бизнесийн орчны судлагдсан байдал.....	10
1.2.2 Зээлийн батлан даалтын судлагдсан байдал .....	14
II БҮЛЭГ. ОНОЛЫН УХАГДАХУУН .....	16
2.1 Жижиг, дунд үйлдвэрийн үүсэл хөгжил, ойлголт .....	16
2.2 Зээлийн батлан даалтын тогтолцооны үүсэл хөгжил, загварууд .....	18
2.2.1 Зээлийн батлан даалтын оновчтой харьцаанд нөлөөлөгч хүчин зүйлс .....	22
2.2.2 Зээлийн батлан даалтын харьцааны эдийн засаг дахь нөлөө .....	23
III БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА, АРГАЗҮЙ.....	24
3.1 Судалгааны дизайн .....	24
3.2 Баримт бичгийн судалгааны арга зүй .....	24
3.3 Харьцуулсан шинжилгээ .....	26
IV БҮЛЭГ. ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ .....	28
4.1 Жижиг, дунд үйлдвэрийн эдийн засаг дахь нөлөөний харьцуулсан шинжилгээ ..	28

4.2	Жижиг, дунд үйлдвэрийн санхүүжилтэд тулгарч буй гол саад бэрхшээл .....	31
4.2.1	Олон улсын ЖДҮ-ийн санхүүжилтэд тулгарч буй бэрхшээл, шийдвэрлэх арга зам, туршлага .....	31
4.2.2	Монгол улсын ЖДҮ-ийн санхүүжилтэд тулгарч буй бэрхшээл, санхүүжилтийн эх үүсвэр .....	33
4.3	Зээлийн батлан даалтын сангийн өнөөгийн нөхцөл байдал .....	36
4.4	Зээлийн батлан даалтын харьцааны харьцуулсан шинжилгээ .....	39
4.4.1	Зээлийн батлан даалтын харьцааны кейс харьцуулсан шинжилгээ .....	40
	ДҮГНЭЛТ.....	47
	САНАЛ ЗӨВЛӨМЖ.....	48
	НОМ ЗҮЙ.....	49
	ХАВСРАЛТ.....	52

**МЭДЭГДЭЛ**

Энэхүү дипломын төсөл нь миний өөрийн бүтээл болохыг баталж байна. Энэхүү бүтээл нь СЭЗИС-ийн оюуны өмч болох бөгөөд дипломын төслийг номын сангаар дамжуулан нийтийн хүртээл болгохыг зөвшөөрч байна.

Нэр: Д.Дорждэрэм

Гарын үсэг:

Огноо: 2024.01.08

## ТАЛАРХАЛ

Энэхүү бакалаврын зэрэг хамгаалах судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд гүн туслалцаа үзүүлж, мэргэжлийн зөвлөгөө, чиглэл өгч мэдлэг чадвар, сэтгэл, цаг заваа харамгүй хайрласан удирдагч багш, доктор Д.Түвшинжаргал, шүүмжлэгч багш, доктор П.Гантөмөр болон үнэтэй зөвлөгөөгөө өгсөн экономиксийн тэнхимийн багш нартаа чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Мөн өөрийн үнэт цаг заваа зарцуулан судалгаанд дэмжлэг үзүүлсэн ЗБДС-ийн мэргэжилтэн Д.Баттогтох, ЖДҮ-ийн газрын мэргэжилтэн Э.Ундрал нартаа баярлалаа.

Судалгааны ажил нь нэг талаас мэдсэнээ бататгах, өөрөө хөгжих процесс хэдий ч, нөгөө талаас цаг хугацаа, тэвчээр, золиос шаардсан ажил байдаг. Энэ тэвчээрийг надад өгч, золиосыг хамт үүрсэн, бүх талаар дэмжин тусалж байсан хайрт гэр бүлдээ талархаж буйгаа тэмдэглэе.

## ТОВЧ ХУРААНГУЙ

Өндөр хөгжсөн болон хөгжиж буй бүхий л улс орнуудын хувьд жижиг, дунд үйлдвэр, гарааны бизнест зориулсан санхүүгийн үйлчилгээний хүртээмж нь эдийн засаг, нийгмийн хөгжлийнх нь томоохон асуудал болжээ. Энэхүү судалгааны ажлаар монгол улсын жижиг, дунд үйлдвэрийн салбарын санхүүжилтийн орчныг сайжруулах, санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд зээлийн батлан даалтын тогтолцооны гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх боломжийг олон улс, хөгжингүй орнуудтай харьцуулан судлалаа. Энэ хүрээнд ЖДҮ-ийн санхүүжилтэд тулгардаг саад бэрхшээлүүдийг тодорхойлж, тэдгээрийн шийдвэрлэх санхүүжилтийн арга хэрэгслүүд, өргөн ашиглагддаг загваруудыг шинжлэв. Судалгааны үр дүнд манай улсын ЖДҮ эрхлэгчид голчлон арилжааны банкны үйлчилгээг ашиглан санхүүжилтийн асуудлаа шийддэг бөгөөд бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд бизнесийн орчин тэр дундаа санхүүжилтийн асуудал хамгийн их бэрхшээл болж байна. Тодруулбал барьцаа хөрөнгийн дутмаг байдал, санхүүгийн үйлчилгээний өндөр хүү зэрэг нь хамгийн том бэрхшээл байна. Уг бэрхшээлийг шийдэхэд хөгжингүй болон хөгжиж буй орны шалгарсан туршлага нь зээлийн батлан даалтын тогтолцоо байна. Гэвч зээлийн батлан даалтын тогтолцоо нь манай улсад хожуу нэвтэрсэн буюу бойжилтын үедээ явж байгаа бөгөөд ЖДҮ салбарт үзүүлсэн нөлөө, гүйцэтгэж буй үүрэг хангалтгүй байна. ЖДҮ-ийн өсөлтийг нэмэгдүүлэхэд бизнес, санхүүгийн таатай орчин нь суурь нөхцөл болдог бөгөөд ЖДҮ-ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд зээлийн батлан даалтын одоогийн тогтолцоог сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал, зээлийн давхар батлан даалтыг нэвтрүүлэх, зээлийн батлан даалтын үйлчилгээ, өмчлөлийг төрөлжүүлэх, зээлийн батлан даалтын харьцааг зарим салбаруудад өсгөх нь зүйтэй.

**Эдийн засгийн бүтээлийн сэтгүүлийн ангиллын индекс:** O1, O4, N2, N8, N3

**Түлхүүр үгс:** Жижиг, дунд үйлдвэр, зээлийн батлан даалтын сан, барьцаа хөрөнгө, зээлийн батлан даалтын харьцаа

**ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 2.1 Монгол улсын ЖДҮ-ийн ангилал.....	18
Хүснэгт 2.2 Дэлхийн банкны ЖДҮ-ийн ангилал .....	18
Хүснэгт 4.1 Зээлийн батлан даалтын сангийн эдийн засагт оруулж буй нөлөө.....	37



## ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1 ЖДҮ-ийн санхүүжилтэд ашиглагддаг санхүүгийн арга хэрэгслүүд .....	4
Зураг 1.2 ЖДҮ-ийн амьдралын мөчлөг, санхүүжилтийн нийтлэг хувилбарууд.....	5
Зураг 2.1 Монгол улсын ЖДҮ-ийн салбарын хөгжлийн түүх .....	17
Зураг 2.2 Итали улсын зээлийн батлан даалтын хоршооны схем, 1840 оны үе .....	19
Зураг 2.3 Герман улсын зээлийн батлан даалтын банкны схем, 1950-1960 оны үе.....	19
Зураг 2.4 Япон улсын зээлийн батлан даалтын схем .....	20
Зураг 2.5 Батлан даалтын харьцааны ЖДҮ-д үзүүлэх нөлөө ба уг харьцаанд нөлөөлөгч хүчин зүйл .....	22
Зураг 3.1 Судалгааны дизайн, аналитик хүрээ .....	24
Зураг 3.2 Баримт бичгийн судалгааны үе шат .....	25
Зураг 4.1 Монгол улсын жижиг, дунд үйлдвэрийн ажил эрхлэлт .....	28
Зураг 4.2 Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж.....	29
Зураг 4.3 Мянган хүн тутамд ногдох ЖДҮ-ийн тоо, 2001-2006.....	29
Зураг 4.4 ЖДҮ-ийн ДНБ-д эзлэх хувь, орлогын ялгаатай улсуудаар .....	30
Зураг 4.5 Жижиг, дунд үйлдвэрийн ажил эрхлэлт, орлогын ялгаатай улсуудаар.....	31
Зураг 4.6 Жижиг, дунд үйлдвэрийн өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлс.....	33
Зураг 4.7 Санхүүжилтийн эх үүсвэр, ЖДҮ-ийн хэмжээгээр.....	35
Зураг 4.8 Санхүүжилтийн эх үүсвэр .....	35
Зураг 4.9 Зээл авах нөхцөлөө хангаагүй шалтгаан.....	36
Зураг 4.10 ЗБДС-ийн эдийн засгийн үзүүлэлт 1 .....	37
Зураг 4.11 ЗБДС-ийн эдийн засгийн үзүүлэлт 2.....	38
Зураг 4.12 Зээлийн батлан даалт гаргах үе шат .....	38
Зураг 4.13 Зээлийн батлан даалтын харьцаа, өндөр орлоготой улстай харьцуулахад ....	42
Зураг 4.14 Зээлийн батлан даалтын харьцаа, дундаас дээш орлоготой улстай харьцуулахад.....	42
Зураг 4.15 Зээлийн батлан даалтын харьцаа, дундаас доош орлоготой улстай харьцуулахад.....	42
Зураг 4.16 Одоогийн зээлийн батлан даалтын загвар .....	43
Зураг 4.17 Санал болгож буй зээлийн батлан даалтын загвар .....	44

**ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ**

Хавсралт А. ЖДҮ-ийн аж ахуйн нэгж, экспорт, бүтээгдэхүүнд эзлэх хувь.....	52
Хавсралт В. ЖДҮ-ийн ажиллагчдын тооны бүлэг, борлуулалтын орлогын бүлгээр.....	53
Хавсралт С. Судлагдсан байдлын оюуны зураглал .....	54
Хавсралт D. Зээлийн батлан даалтын үзүүлэлтүүд, орлогын ялгаатай улсуудаар .....	55

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

<b>Нэршил товчлол</b>	<b>Тайлбар</b>
<b>АХБ</b>	Азийн хөгжлийн банк
<b>ЕХ</b>	Европын Холбоо
<b>ЖДҮ</b>	Жижиг, дунд үйлдвэр
<b>ЖДҮХС</b>	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
<b>ЖДҮҮДТХ</b>	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль
<b>ЗБДС</b>	Зээлийн батлан даалтын сан
<b>ЗБДТ</b>	Зээлийн батлан даалтын тогтолцоо
<b>ЗБДХ</b>	Зээлийн батлан даалтын харьцаа
<b>ЗБДК</b>	Зээлийн батлан даалтын корпораци
<b>ҮСХ</b>	Үндэсний статистикийн хороо
<b>ҮХЯ</b>	Үйлдвэрлэлийг хөгжүүлэх яам
<b>ХХААХҮЯ</b>	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
<b>CGS</b>	Credit guarantee system
<b>CGR</b>	Credit guarantee ratio
<b>JFC</b>	Japan Finance Corporation
<b>KODIT</b>	Korea Credit Guarantee Fund
<b>NFCGC</b>	National Federation of Credit Guarantee Corporations

## ОРШИЛ

Жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ) нь хөгжиж буй орнуудын бизнес эрхлэгчдийн дийлэнх хувийг эзэлдэг бөгөөд ажлын байр бий болгох замаар эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулж байна. Тухайлбал, ЖДҮ нь дэлхийн нийт бизнесийн 90 орчим хувь, ажил эрхлэлтийн 50 гаруй хувийг, хөгжиж буй орнуудын ДНБ-ий 40 хувийг дангаар бүрдүүлж байна. Иймд ЖДҮ-ийн салбарыг дэмжих, хөгжүүлэх нь ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахын зэрэгцээ хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгох гол тулгуур болно (Монгол банк, 2022). Манай орны хувьд жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ), бичил бизнес нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох, ажилгүйдэл болон ядуурлыг бууруулахад ачааны хүндийг үүрч байна (UNDP, 1999; Worldbank, 2012).

Эдгээр ЖДҮ эрхлэгч ААН-үүдэд зах зээл дээр эргэлтийн хөрөнгөө удирдах, өсгөх, өрсөлдүүлэх чадамжтай байх шаардлагатай учраас том байгууллагуудаас илүү зээлийн хэрэгцээ тулгардаг байна. Иймд санхүүгийн хүртээмж нь тэдний амжилтад нэн чухал нөлөөтэй юм. Гэвч өндөр хөгжсөн болон хөгжиж буй бүхий л улс орнуудын адил манай орны ЖДҮ, гарааны бизнест зориулсан санхүүгийн үйлчилгээний хүртээмж нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн томоохон асуудал хэвээр байна. Тодруулбал, санхүүгийн үйлчилгээний хүртээмж өсөн нэмэгдэж байгаа хэдий ч уг үйлчилгээг хүртэж чаддаггүй иргэд, аж ахуйн нэгжийн тоо өндөр хэвээр байна.

Цаашилбал ЖДҮ нь үйл ажиллагаа болон бусад хэлбэрээр санхүүжилт авахад томоохон сорилтуудтай тулгарч байгаа ба тодруулбал, ЖДҮ-д зээл олгохдоо барьцаа хөрөнгийн шаардлага хэт өндөр буюу улам нэмэгдэх хандлагатай байгаа нь тус салбарын өсөлтийг хязгаарлаж байна. Азийн бусад орнуудад ч мөн ЖДҮ-д дээрх шалтгаанаар санхүүжилт авахад хүндрэлтэй байгаа нь Азийн эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлт, ялангуяа хөгжиж буй орнуудад аюул учруулж болзошгүй байна. Энэ нь бага, дундаас доош орлоготой орнууд болон манай улс ЖДҮ-ийн санхүүжилтийг цаашид бодлогоор дэмжих шаардлагатай байгааг харуулж байна. Үүнд Азийн ихэнх орнууд болон манай орон нь банк давамгайлсан эдийн засагтай учир хөрөнгийн зах зээлийн санхүүжилт нь ЖДҮ-ийн хувьд бодит үр дүнтэй хувилбар биш тул арилжааны банкнаас ЖДҮ-д олгох зээлийг хөнгөвчлөх, эрсдэлийг бууруулах шийдлүүдийг эрэлхийлэх шаардлагатай байна (Asian Development Bank, 2018).

Хөгжингүй болон хөгжиж буй орнуудын ЖДҮ-ийн бодлогын салшгүй хэсэг нь зээлийн батлан даалтын тогтолцоо бөгөөд дээрх асуудлыг шийдвэрлэхэд хамгийн түгээмэл ашиглагдаж байна. Гэвч зарим улс орнуудад уг тогтолцооны эдийн засаг, ажил эрхлэлтэд үзүүлж буй нөлөө нь өсөлтийг бий болгож байхад заримд нь үр дүн нь тодорхойгүй, ахиц дэвшил муу байгаа нь зээлийн батлан даалтын тогтолцоо улс орнуудад харилцан адилгүй түвшинд хөгжсөнийг илтгэж байна. Үүнээс хөгжингүй болон хөгжиж буй орнуудын ЗБДТ-ны давуу болон сул тал, ялгаатай байдлыг тодорхойлж, тулгамдаж буй бэрхшээл, нөлөөлөгч хүчин зүйлсийг шинжилж улмаар ЖДҮ-ийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох нь чухал байна.

Судалгааны асуудлын хүрээнд дараах асуултуудыг дэвшүүлж байна.

- **Асуулт 1.** Манай улсад зээлийн батлан даалт нэвтэрснээр ЖДҮ салбар болон эдийн засагт хангалттай үр нөлөөтэй байна уу?
- **Асуулт 2.** ЖДҮ-ийн өсөлтөд хамгийн их саад учруулж буй хүчин зүйл юу вэ?
- **Асуулт 3.** ЖДҮ-ийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд зээлийн батлан даалт нь үр дүнтэй хувилбар мөн үү?

**Судалгааны зорилго:** Энэхүү судалгааны ажлын зорилго нь монгол улсын жижиг, дунд үйлдвэрийн салбарын санхүүжилтийн орчныг сайжруулахад зээлийн батлан даалтын тогтолцооны гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх боломжийг судлахад оршино.

**Судалгааны зорилт:** Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ.

- Монгол Улсын ЖДҮ-ийн өнөөгийн байдлыг судлах
- ЖДҮ-ийн санхүүжилтэд тулгардаг саад бэрхшээлүүдийг тодорхойлох
- ЖДҮ-ийн санхүүжилтийн арга хэрэгслүүд, өргөн ашиглагддаг загваруудыг судлах
- ЖДҮ-ээр тэргүүлдэг улс орнуудын туршлагыг судлах
- Монгол Улсын ЗБДТ-ны өнөөгийн байдлыг судлах
- Зээлийн батлан даалтын тогтолцооны загваруудыг судлах
- ЗБДТ-г сайжруулснаар ЖДҮ-д үзүүлэх нөлөөг тодорхойлох
- Судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах

**Судалгааны таамаглал:** ЖДҮ-ийн санхүүжилт болон зээлийн батлан даалтын олон улс ба дотоодод хийгдсэн судалгааны ажлуудад үндэслэн дараах таамаглалуудыг дэвшүүлж байна. Үүнд:

**Таамаглал 1:** ЖДҮ нь том компанитай харьцуулахад санхүүжилтийн хүрэлцээ муу бөгөөд санхүүжилт авахад илүү хүндрэлтэй байдаг.

**Таамаглал 2:** Олон улсад ЖДҮ-ийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд ЗБДС-г түгээмэл ашигладаг.

**Таамаглал 3:** Эдийн засаг өргөжихийн хэрээр ЖДҮ-д үзүүлэх ЗБДС-ийн бүтээгдэхүүн үйлчилгээ, өмчлөл төрөлждөг.

## **I БҮЛЭГ. НОМ ЗҮЙН ТОЙМ БУЮУ СУДЛАГДСАН БАЙДАЛ**

### **1.1 Онолын судлагдсан байдлын тойм**

#### **1.1.1 Бичил санхүү**

Бичил санхүүгийн үйлчилгээ нь тодорхой нөхцөл байдалд ядуурал, эмзэг байдлыг бууруулахад хамгийн үр дүнтэй санхүүгийн хэрэгсэл ба бичил аж ахуйн нэгжүүдэд хадгаламж, зээл, төлбөрийн үйлчилгээ гэх мэт өргөн хүрээний санхүүгийн хэрэгсэл гэж тодорхойлж болно (АХБ, 2000). Бичил санхүүгийн хэрэгсэл нь эдийн засгийн даяаршил, ядуурал, эмзэг байдлыг бууруулах стратеги, ажилгүйдлийг бууруулах, эмэгтэйчүүдийг чадавхжуулах арга замуудтай харилцан уялдаатай байдаг. Сүүлийн гучин жилийн хугацаанд бичил санхүүгийн онолын хэрэглээ нэмэгдэж, үүний дотор ядуурал, нийгэм эдийн засгийн эмзэг байдлыг шийдвэрлэх арга хэрэгсэл болгон олон улсын хэмжээнд хуульчлагдсан байна. 1997 онд Вашингтонд болсон бичил зээлийн дээд хэмжээний уулзалтаар бичил санхүүгийн хэрэгслийг ядуурлыг бууруулах "гайхамшигт хэрэгсэл" гэж үзжээ. Тодруулбал хамгийн ядуу бүлэгт хүрэх, эмэгтэйчүүдийг чадавхжуулах, бие даасан санхүүгийн байгууллагуудыг бий болгох, үйлчлүүлэгч болон тэдний ар гэрт эерэг, хэмжигдэхүйц нөлөө үзүүлэх гэсэн үндсэн дөрвөн чухал нөлөөтэй гэж онцолжээ.


Ядуурлыг бууруулах, ажилгүйдлийг бууруулах бичил санхүүгийн талаар асар их эмпирик судалгаа болон онолын ном зохиол байдаг ба бичил санхүү нь ядуучуудын амьдрах боломжуудыг нэмэгдүүлэх стратегийн санхүүжилт гэж үздэг. Гэсэн хэдий ч бичил санхүүгийн ядууралд үзүүлэх нөлөө, эмзэг байдлыг бууруулах талаар одоо байгаа нотолгоо хоёрдмол утгатай байна. Зарим судалгааны ажил бичил санхүүгийн хүртээмж нь ядуурлыг мэдэгдэхүйц бууруулах боломжтойг харуулж байна.

Банк бус санхүүгийн байгууллага, банк, хоршоо, зээлийн хоршоо, төрийн бус байгууллага нь ямар хэлбэр, хэмжээтэй байхаас үл хамааран харилцагч болон пүүс, өрхүүдэд мөнгөний менежмент, банкны үйлчилгээ үзүүлэхийг эрмэлздэг. Бичил санхүү нь ядуу хүмүүсийг, ялангуяа эмэгтэйчүүдийг албан ёсны санхүүгийн системээс тусгаарлагдсан асуудлыг шийдвэрлэх стратеги болтлоо хөгжсөн. Ядуурал, эмзэг байдлыг бууруулах хэрэгсэл болох бичил санхүү иргэдэд зээлийн хүртээмжийг сайжруулах нь эдийн засгийн үйл ажиллагааны өгөөжийг сайжруулах суурь болдог. Энэ нь хувиараа хөдөлмөр эрхлэлтийг өргөжүүлж, бизнес эрхлэх үйл ажиллагааг дэмждэг ба орлого өсөх боломжийг олгож, эмзэг байдлыг бууруулдаг.

### 1.1.2 Санхүүгийн институт

Зураг 1.1-д жижиг, дунд үйлдвэрийг (ЖДҮ) дэмжихэд хэрэглэгддэг санхүүжилтийн хэрэгслүүдийг харуулав. Томоохон аж ахуйн нэгжүүдийн хувьд санхүүжилтээ хөрөнгийн зах зээлд оролцох, олон нийтэд хувьцаагаа арилжаалах замаар хөрөнгө босгох, арилжааны банкнаас үйлчилгээ авч санхүүжилтээ шийдвэрлэж байна. Мөн өндөр хөгжилтэй орнуудын арилжааны банкнууд ЖДҮ эрхлэгчдэд санхүүгийн таатай бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгодог. Харин хөгжиж буй орнуудын арилжааны банкнууд ЖДҮ-д тохирсон үйлчилгээг байнга нэвтрүүлж чаддаггүй. ЖДҮ-д зориулсан бичил санхүүгийн байгууллагууд жижиг зээлийн бизнес загваруудыг амжилттай хөгжүүлж, хэрэгжүүлж байгаа хэдий ч тэдний нөөц хязгаарлагдмал байгаа нь эдгээр аж ахуйн нэгжүүдийг өргөжүүлэхэд саад болж байна. Иймээс улс орнуудын ЖДҮ эрхлэгчдийг санхүүжүүлэх үндсэн эх үүсвэр нь бичил санхүүгийн байгууллагуудын санал болгож буй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ байна.


Зураг 1.1 ЖДҮ-ийн санхүүжилтэд ашиглагддаг санхүүгийн арга хэрэгслүүд



Эх сурвалж: (Санхүүгийн зохицуулах хороо, 2021)

Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн хэрэгцээ нь амьдралын мөчлөгөөс хамааран өөр өөр байдаг бөгөөд эдгээр хэрэгцээг хангахын тулд янз бүрийн санхүүгийн арга хэрэгслийг ашигладаг бөгөөд үүнийг дараах зурагт харуулав (Зураг 2).

Зураг 1.2 ЖДҮ-ийн амьдралын мөчлөг, санхүүжилтийн нийтлэг хувилбарууд



Эх сурвалж: Европын холбооны ЖДҮ-ийн хороо, 2010

Дийлэнх бизнес эрхлэгчид бизнесийн санаагаа анх хэрэгжүүлэх үедээ хувийн хөрөнгөө ашиглан бизнесээ эхлүүлдэг. Эхлэлийн үе шатанд мэдлэг, туршлага, тууштай байдал, шаргуу хөдөлмөр зэрэг хүчин зүйлүүд чухал байдаг. Мөн бизнесээ эхлүүлэхдээ гэр бүл, найз нөхөд, ах эгч нараасаа санхүүгийн дэмжлэг авах нь түгээмэл байдаг ч бичил санхүү, эхлэлтийн санхүүжилт олгох түншийн дэмжлэг, төрийн ба хувийн бизнес инкубаторууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Эхний үе шатыг амжилттай даван туулах нь бизнесийг өргөжүүлэх боломжийг бий болгодог. Гэсэн хэдий ч нийтлэг тохиолдолд энэ үе шатанд тэдгээр бизнес эрхлэгчдийн хуримтлагдсан ашиг нь дараагийн санхүүжилтийн хэрэгцээнд хангалтгүй байдаг тул банк, санхүүгийн байгууллагаас зээл авах шаардлагатай болдог.

Бизнес эрхлэгчдэд бизнесийн туршлага, барьцаа хөрөнгө хязгаарлагдмал зэргээс шалтгаалан банкны зээл авах нь бэрхшээлтэй тул зээлийн батлан даалт, венчур капиталын үйлчилгээ авах шаардлагатай болдог. Жижиг, дунд үйлдвэрүүд (ЖДҮ) хөгжлийн тогтворжих шатандаа банк ба хөрөнгийн зах зээлээс санхүүгийн дэмжлэг авах шаардлагатай болдог. Харин нөхцөл байдал муугаар эргэсэн тохиолдолд үйл ажиллагаа болон бусад хүчин зүйлийн нөлөөгөөр санхүүгийн хувьд уналтад орж улмаар дампуурах эрсдэлтэй байдаг.



### 1.1.3 Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төрийн оролцооны үзэл баримтлалууд

Жижиг, дунд үйлдвэрүүдэд тулгарч буй санхүүжилтийн гол бэрхшээлүүдийн нэг нь мэдээллийн тэгш бус байдал, гүйлгээний өндөр өртөг юм. Зарим банк, санхүүгийн байгууллагууд ЖДҮ-д тохирсон зээлийн бүтээгдэхүүн бий болгохын тулд судалгаа хийж болох ч ЖДҮ-д олгосон зээл хангалттай үр ашигтай байна гэдэгт эргэлздэг тул судалгаа, шинжилгээ хийх сонирхол бага байдаг. Цаашилбал, ЖДҮ-д тохирсон зээлийн бүтээгдэхүүн боловсруулж гаргалаа гэхэд бусад аж ахуйн нэгжүүд судалгааны зардал гаргахгүйгээр хуулбарлахад хялбар байдаг нь болгоомжлолыг үүсгэдэг. Ийм нөхцөлд ЖДҮ-д тохирсон санхүүгийн бүтээгдэхүүн боловсруулах нь нийгмийн үүрэг болдог. Үүнд санхүүгийн хөгжлийг дэмжихийн тулд зарим тохиолдолд төрийн оролцоо зайлшгүй шаардлагатай болдог гэж ихэнх эдийн засагчид үздэг. Энэ талаар судлаачид төр огт оролцохгүй байх, төр шууд оролцох гэсэн хоёр үзэл баримтлалтай байна.

Төрийн шууд оролцооны үзэл баримтлалыг дэмжигчид зах зээлийн санхүүжилтийн хүртээмжид тулгарч буй бэрхшээлийг зах зээл дангаараа шийдвэрлэж чадахгүй тул санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн ЖДҮ-д хуваарилахад төрийн оролцоо чухал гэсэн санааг үндэслэл болгож байна. Харин төр огт оролцохгүй байх буюу "битгий оролц" үзэл баримтлалыг дэмжигчид санхүүгийн зуучлалд засгийн газар шууд оролцох нь хор уршгийг илүү бий болгодог, зах зээлийг тэнцвэрээс холдуулдаг гэж үздэг. Тиймээс "битгий оролц" үзэл баримтлалыг дэмжигчид засгийн газар санхүүжилтийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохоос илүүтэйгээр банк, санхүүгийн байгууллагуудад тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд туслах, бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд анхаарлаа хандуулах хэрэгтэй гэж үздэг байна.

#### 1.1.3.1 Төрийн шууд оролцооны үзэл баримтлал

Шууд оролцооны үзэл баримтлал нь 1950-1960-аад оны үед импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэхтэй уялдан бий болжээ. 1962 онд эдийн засагч, улс төрч Гершенкрон хөгжиж буй орнуудад зах зээл өөрөө санхүүжилтийн хүртээмжийн асуудлыг бие даан шийдэж чадахгүй гэсэн үзлийг дэвшүүлжээ. Тухайн үед зах зээл асуудлыг яагаад шийдэж чадахгүй байна вэ гэдгээс илүү зах зээл өөрөө шийдэж чадахгүй байна гэдэг нь чухал санааг илэрхийлж байжээ. Зээл авч чаддаг чинээлэг айл өрх, аж ахуйн нэгжүүдийн хүрээг тэлж бусдад санхүүжилтийн боломжийг хүргэхэд засгийн газрын үүрэг чухал гээд санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд дараах арга хэрэгслийг ашигласан байна. Үүнд:

**Төрийн болон хөгжлийн банк байгуулж сан бүрдүүлэх:** Энэ арга хэмжээний үр дүнд төрийн банкнууд байгуулагдсан ба 1970 он гэхэд хөгжингүй орнуудад банкны активын 40 хувийг, хөгжиж буй орнуудад 65 хувийг, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай улс орнуудад 100 хувийг төр эзэмшиж байжээ. Төрийн банкнууд нь улс орнуудад нийгмийн бөгөөд хөгжлийн зорилтуудаа хэрэгжүүлэхэд ашигладаг гол хэрэгсэл болжээ. Энэ тохиолдолд ихэвчлэн сонгогдсон бүлэгт хямд буюу хөнгөлттэй зээл олгодог байв. Ялангуяа, хувийн банкнуудын хүрч чадахгүй байгаа, жишээлбэл урт хугацаатай зээл,

жиг, дунд үйлдвэрийн санхүүжилт, орон сууцны болон хөдөө аж ахуйн санхүүжилт гэх мэтийг зах зээлд нийлүүлдэг байжээ. Төрийн банк байгуулан ажилласны үр дүн нь:

- Жижиг, дунд үйлдвэрийн талаар мэдээлэл олж авах, хяналт тавихдаа өөрийн институцийг ашиглах боломжтой тул буруу сонголт хийх явдлыг багасгаж, гүйлгээний зардлыг бууруулсан.
- Засгийн газар эдийн засгийн боломжоо ашиглаж зээл олгохтой холбоотой тогтмол зардлыг бууруулж ашигт ажиллагааг нэмэгдүүлсэн.
- Иргэдийн банканд итгэх итгэлийг нэмэгдүүлж иргэд мөнгөө банканд хадгалуулах сонирхлыг бий болгож санхүүгийн зах зээлийг хөгжүүлсэн зэрэг үр дүнг бий болгосон.

Засгийн газар хууль эрх зүйн таатай орчныг бий болгож ялангуяа хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлж иргэдийн санхүүгийн салбарт итгэх итгэлийг төлөвшүүлж болно. Мөн банкнуудын хяналт шалгалтыг хэр хийж чадаж байна, төрийн банкиг яаж хянаж байна вэ гэдэг чухал. Хэрэв иргэд хувийн банкнаас илүү төрийн банканд итгэж мөнгөө хадгалуулж байгаа бол төрд хөрөнгийн эх үүсвэр хангалттай бий болно (Andrianova, 2002).

Дээр дурдсан эерэг үр дүнгээс гадна олон сөрөг үр дүн гарсан байна. Банкны өмчлөлд засгийн газрын оролцоо их байх тусам санхүүгийн хөгжил тухайн оронд сул, хувийн хэвшилд олгож буй зээлийн хэмжээ бага, хадгаламж, зээлийн хүүгийн зөрүү их, зээл аль нэг салбарт төвлөрөх хандлага их, эдийн засгийн өсөлт илүү удаан байна. Үүнд дараах шалтгаанууд байж болох юм. Үүнд:

- Сонгосон бүлэгт хүрч чадаагүй, хүрч чадсан бол хэт өндөр үнэтэй байсан
- Зээлийн шинжилгээг муу хийсэн, зээлийн эргэн төлөлт муу (ингэснээр санхүүгийн сахилга батыг сулруулсан)
- Захиргааны зардал их өндөр, олон хүн ажиллуулах хандлага, авлигал, улс төрийн оролцоо болон ашиг сонирхлын зөрчилдөөн их зэрэг болно.

**Зорилтот бүлэгт чиглүүлсэн зээл:** Зээлийн нөхцөлийг хувийн банкнуудад тулгах, засгийн газар хувийн банкиг зээлийнхээ тодорхой хувийг аль нэг эдийн засгийн салбарт юм уу орон нутагт олгохыг шаарддаг. Жишээлбэл, Бразилд арилжааны банкнуудаас орон нутгийнхаа хадгаламжийн 20-60 хувийг (банкны хэмжээнээс хамаарна) хөдөө аж ахуйн зээлд олгохыг шаардаж байв. Энэтхэгт банкнууд хадгаламжийнхаа 50 хувиар засгийн газрын бондыг зах зээлийн үнээс хямдаар худалдан авах ёстой байсан ба үлдсэн хөрөнгийн ихэнх хувийг хөдөө аж ахуй, жижиг үйлдвэр эрхлэгчдэд олгож, зөвхөн 20 хувийг л өөрсдөө шийдэх боломжтой байжээ (Booth, 2001). Банкнуудыг зорилтот бүлэгт зээл олгохыг шаардсан бодлого Япон, Өмнөд Солонгос, Тайван зэрэг улсаас бусад улсад амжилтгүй болжээ. Ихэвчлэн ийм зээл нь зорилтот бүлэгтээ хүрч чадаагүй, тухайн бүлгийн нөлөө сайтай том зээлдэгчид үр шимийг илүүтэйгээр хүртэх хандлагатай байсан тул зах зээлийн гажуудлыг засахаас илүүтэйгээр улс төрийн холбоотой этгээдэд зээл олгох арга хэрэгсэл болж, уг хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх өртөг их өндөр гарсан байна.

**Зээлийн хүүний зохицуулалт:** Зарим салбарт хүүний хөнгөлттэй зээл олгох төслийг засгийн газрууд хэрэгжүүлдэг. Жишээлбэл, Колумбад 1983-1987 (Дэлхийн банк, 1990) тусгай зориулалттай зээлийн хүү арилжааны зээлийн хүүнээс дунджаар 12 нэгжээр бага, Туркид 1980-1982 оны хооронд энэ зөрүү 36 нэгжид хүрч (Дэлхийн банк, 1989), Монголд 2006-2007 онуудад газар тариалангийн зээлийн хүүг арилжааны зээлийн хүүнээс 50 хувиар бага тогтоож засгийн газар зөрүүг банкнуудад төлж байсан туршлага байна. Энэ хэрэгслэлийг ашиглахдаа зээл, хадгаламжийн хүүний дээд түвшнийг тогтоодог байна. Засгийн газар хүүг хянаж, санхүүжилтийн өртгийг бууруулж зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой байдаг. Гэхдээ, зээлийн хүүг хянах нь зөвхөн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлээд зогсохгүй мөнгөний хатуу бодлогыг барих, банкны салбарыг илүү сайн хянах, мөнгөний нийлүүлэлтийг удирдан төрийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэртэй болох боломжийг засгийн газарт олгодог байна (Roubini, Sala-i-Martin, 1992).

### 1.1.3.2 Төрийн "Битгий оролц" үзэл баримтлал

Дээр дурдсан төрийн шууд оролцооны сөрөг нөлөөллийг эсэргүүцсэний үр дүнд "битгий оролц" үзэл баримтлал хөгжиж ирсэн түүхтэй. "Битгий оролц" үзэл баримтлалын гол санаа нь төр хэзээ ч сайн санхүүч байж чадахгүй, харин үл хөдлөх хөрөнгийн зохицуулалтыг сайжруулж, хууль эрх зүйн орчныг бүрдүүлж өгвөл санхүүгийн зах зээл өөрөө зөв шийдлээ олж чадна гэдэгт оршиж байна. Засгийн газраас бэрхшээлийг шийдэхийн тулд зарцуулсан хөрөнгө нь зах зээлийн шийдлээс илүү өндөр өртөгтэй байдаг. Иймд, төр банк, санхүүгийн байгууллагыг эзэмших, зээлийн нөхцөл тулгах, зээлжилтийн явцад шууд оролцох хэрэггүй, харин таатай орчныг бүрдүүлж өгөх хэрэгтэй гэдгийг энэ үзэл баримтлал санал болгож байна. Таатай орчин гэдэгт макро эдийн засгийн тогтвортой орчин, зээлдэгч, зээлдүүлэгчийн эрх ашгийг хамгаалсан хууль эрх зүйн орчин, зохистой харьцааг шинэчлэн хяналт, зохицуулалтыг боловсронгуй болгох, нягтлан бодох бүртгэлийн стандартыг шинэчлэх, зээлийн мэдээллийн тогтолцоог бий болгох зэрэг багтаж байна (Rajan, Zingales, 2001: Дэлхийн банк, 2005a).

Энэхүү үзэл баримтлалын дагуу төрийн оролцоог хязгаарлаж, санхүүгийн зах зээлийг хөнгөлөлттэй зээл, татаас, өмчлөл гэх мэтээр гажуудуулахгүй байх нь эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлнэ. Иймээс, засгийн газар макро эдийн засгийн орчныг тогтвортой байлгах, мөнгөний бодлогыг сайжруулахад анхаарлаа хандуулж санхүүгийн либералчлалыг хийсэн байна. "Битгий оролц" үзэл баримтлалын хүрээнд засгийн газрууд дараах арга хэмжээг авчээ. Үүнд:

- Буруу сонголт хийх аюулыг бууруулахын тулд дампуурлын хуулийг шинэчилж, зээлдүүлэгч байгууллагын эрхийг хамгаалах шинэ хуулийг санаачилсан байна.
- Мэдээлэл солилцоог сайжруулахын тулд зээлийн мэдээллийн сан байгуулахыг дэмжсэн. Төрийн өмчлөл бүхий зээлийн мэдээллийн сан байгуулаад зогсохгүй мөн хувийн мэдээллийн сан байгуулахыг дэмжиж таатай орчныг бүрдүүлэхэд анхаарчээ. Үүний үр дүнд 1989 оноос хойш 15 оронд төрийн мэдээллийн сан байгуулагдаж одоо ажиллаж буй хувийн мэдээллийн сангийн бараг тал нь энэ үед байгуулагдсан байна (Miler, 2003).

- Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газрыг байгуулж барьцаа хөрөнгийн хуулийг шинэчилжээ
- Мөн хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд чиглэсэн хууль эрх зүйн болон бүтцийн шинэчлэлийг хийсэн байна. Зарим судлаачид эдгээр шинэчлэл нь санхүүгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлсэн гэж үздэг. Үүнд:
- Зээлдэгчийн эрх сайжирч зээлийн мэдээллийн сан байгуулагдсан нь хувийн хэвшлийн зээлжилттэй шууд эерэг хамааралтай (Djankov, McLiesh, Shleifer, 2006).
- Хөрөнгийн зах зээлийн шинэчлэл нь хөрөнгийн биржийн капиталыг нэмэх, худалдааг өргөжүүлэхэд нөлөөлсөн (De la Torre, Gozzi, Schmukler, 2005).
- Санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд олон эерэг үр дүн гарсан ба үүний нэг нь бичил санхүүгийн хөгжил юм.

Ийм эерэг үзүүлэлт байхад яагаад улс төрчид болон судлаачид сэтгэл дундуур байна вэ? Магадгүй тэд хэт өндөр хүлээлттэй байсантай холбоотой. Хэдий олон арга хэмжээ авсан ч 1990 оны эхэн үеэс хойш хөгжиж буй орнуудад санхүүжилтийн хүртээмжийн асуудал сайжирсангүй. Олон оронд хадгаламжийн хэмжээ нэмэгдсэн ч хувийн хэвшил, ялангуяа жижиг, дунд үйлдвэрийн зээлжилтийг энэ хэмжээгээр нэмсэнгүй, харин төрийн өмчлөлттэй том аж ахуйн нэгжүүдийг санхүүжүүлсэн. Үүний гол шалтгаан нь төв банкнууд мөнгөний бодлогыг зохицуулах арга хэрэгсэл болгон бондыг их хэмжээгээр гаргасан, хямралын дараа олон оронд банкнуудын бүтцийн өөрчлөлтийг хийсэн, төсвийн алдагдал ихтэй байсан зэрэг болно. Хямралд өртөөгүй болон төсвийн алдагдал багатай байсан улс орнуудад хувийн хэвшлийн зээл илүү ихээр өссөн байна (Hanson, 2003). Мөн хөрөнгийн зах зээл ч хөгжиж буй ихэнх орнуудад сайн хөгжсөнгүй (Дэлхийн банк, 2004)

Дэлхийн олон оронд шинэчлэлийн тухай их яригдаж хэрэгжсэн нь бага байжээ. Тухайлбал, хууль гарсан ч түүнийг хэрэгжүүлээгүй гэсэн алдаа дутагдал их гарчээ. Хууль батлах амархан ч түүнийг зохистой хэрэгжүүлэх, дагалдах бусад өөрчлөлтийг хийх нь амар биш бөгөөд илүү их хугацаа шаарддаг аж.

Мөн бүх улс оронд тохирох бэлэн нэг загвар байхгүй ба тухайн улсын уламжлал, түүхэн хөгжилтэй уялдан хамт хөгжинө. Таатай орчин бүрдүүлнэ гэдэг тухайн улс орны төр, захиргааны бүтцийн хөгжил, зах зээлийн өөрчлөлттэй уялдан байнгын шинэчлэл хийх процесс юм.

## **1.2 Эмпирик судалгааны судлагдсан байдлын тойм**

### **1.2.1 ЖДҮ-ийн бизнесийн орчны судлагдсан байдал**

Жижиг, дунд үйлдвэр нь улс орны эдийн засагт чухал хувь нэмэр оруулж, эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөөлөхийн зэрэгцээ ажилгүйдэл, ядуурлыг бууруулах стратегийн гол хэрэгсэл болдог. Хэдийгээр хөгжилд ЖДҮ-ийн гүйцэтгэх үүргийн талаар судлаачид санал нэг байгаа ч ЖДҮ-ийн эдийн засаг дахь ач холбогдлын талаар хоёр өөр үзэл баримтлалтай байдаг. Тодруулбал судлаачид ЖДҮ-г дэмждэг болон дэмждэггүй гэсэн хоёр үзэл баримтлалд хуваагддаг ба судалгааны хувьд ЖДҮ-г дэмжсэн судалгааны бүтээл зонхилж байна.

ЖДҮ-ийн эдийн засаг дахь нөлөөг чухалчилдаг буюу ЖДҮ-г дэмжсэн судлаачид ЖДҮ нь өрсөлдөөн, энтрепренёр сэтгэлгээ, шинэлэг санааг бий болгож бүтээмжийн өсөлтийг нэмэгдүүлэх замаар эдийн засагт томоохон хувь нэмэр оруулдаг, том хэмжээтэй ААН-үүдтэй харьцуулахад бүтээмж өндөр, автоматжуулалт бага тул ажлын байр бий болгох боломж илүү байдаг гэж үзэж, том ААН бүр жижгээс эхэлдгийг онцолж байна. Харин ЖДҮ-ийн эдийн засаг дахь нөлөөг багаар үнэлдэг буюу ЖДҮ-г дэмждэггүй судлаачид том корпорацуудтай харьцуулахад ЖДҮ нь эдийн засгийн нөөц хязгаарлагдмал тул зах зээлийн нарийн судалгаа, дүн шинжилгээ хийх, улмаар бүтээгдэхүүнийхээ чанарыг сайжруулах, боловсронгуй болгох чадавх муу, илүү олон ажлын байр бий болгож чаддаггүй, бизнесийн орчин таатай биш гэж үзжээ.

Дээрх байр сууринаас үзэхэд жижиг, дунд үйлдвэрийн ач холбогдлын талаар судлаачид нэгдсэн саналд хараахан хүрээгүй байна. Гэвч улс орнууд ЖДҮ-ийн эдийн засаг, бизнест үзүүлж буй нөлөө, ач холбогдлыг чухалчилж байгаа тул ЖДҮ-г дэмжих талын судалгаа түлхүү хийгдсээр иржээ. Үүнээс дараагийн хэсэгт ЖДҮ-г дэмжих нь зүйтэй гэж үзээд энэ хүрээнд хийгдсэн ЖДҮ-ийн бизнесийн орчин, эдийн засаг дахь нөлөө, санхүүжилтийн талаар дотоод болон олон улсад судлагдсан байдлыг тоймлов.

#### **1.2.1.1 Монгол улсад судлагдсан байдал**

Манай улсын хувьд хүн ам цөөн, ДНБ бага, улс төрийн тогтворгүй байдал, импортод тулгуурласан хэрэглээ өндөр, уул уурхайгаас хэт хамааралтай эдийн засагтай зэргээс жижиг, дунд үйлдвэрийг хөшүүрэг болгон ашиглах нь урт болон богино хугацаанд эдийн засгийг дэмжих, үйлдвэрлэгч орон болох боломжтойг дотоодын судлаачид онцолдог. ЖДҮ-ийн санхүүжилтийн асуудлыг тодорхойлох, түүнийг шийдэх арга зам, боломжийн талаар 1995 оноос хойш хөгжингүй орнууд, 2003 оноос хойш буюу ЖДҮ бизнест арилжааны банкнаас зээл олгож эхэлсэнтэй зэрэгцэн дотоодын судалгаа өргөн хүрээтэй хийгдэж эхэлсэн ба 2015 оноос эрчимтэй хийгдсэн байна. Асуудлын хүрээнд дотоодод хийгдсэн судалгаанууд ЖДҮ-ийн бизнест тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох, шийдэх арга замыг эрэлхийлсэн бөгөөд өнөөгийн нөхцөл байдлыг судлан тохирох санхүүжилтийн хэрэгслүүд, арга замыг санал болгожээ. Үүнд асуудлын учир шалтгаан, холбоо хамаарал, шалтгаан үр дагаврыг тодорхойлсон, нөхцөл байдлыг харгалзан үзсэн, хэрэглээний тоон шинж чанартай судалгаанууд давамгайлж байна.

Монгол банкнаас эрхлэн гаргадаг жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал (2018) түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдэд үйл ажиллагаа явуулахад улс төр, нийгмийн байдал зохих хэмжээнд эергээр нөлөөлж чадахгүй байгаа үр дүнтэй байна. Тухайлбал, улс төрийн тогтворгүй байдал, авлига, хээл хахууль нь ЖДҮ-ийн өсөлтөд саад болж буй гол хүчин зүйл болсон. Мөн санхүүжилтийн үндсэн нөхцөл буюу зээлийн хүү нэмэгдсэн, эргэн төлөгдөх хугацаа богино, шимтгэл хураамж хэт өндөр байгаа нь бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна гэж бизнес эрхлэгчид үзэж байна. ЖДҮ эрхлэгчдийн талаас илүү хувь нь нэмэлт санхүүжилт шаардлагатай байгааг харуулж, 10-50 сая төгрөгийн урт хугацаатай, дунджаар 4.8 жилийн хугацаатай зээл хүсэж байна. Цашилбал, шаардлагатай санхүүжилтийн хэмжээг үйл ажиллагаа эрхэлж буй хугацаагаар нь авч үзвэл 3-аас доош жил ажилласан туршлагатай ЖДҮ эрхлэгчид 50 хүртэлх сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай байгаа бол 3-аас дээш жил үйл ажиллагаа явуулж буй иргэд 10 саяас 500 сая төгрөг хүртэл төгрөгийн санхүүжилт авахыг хүсжээ (Монгол банк, 2018).

Н.Амарсайхан (2016) судалгаандаа Монголд венчур капиталын санхүүжилтийг хэрэгжүүлэх боломжийн талаар олон улсын туршлага дээр суурилсан судалгаа хийжээ. Шинжилгээндээ венчур капиталын хөгжлийн эхний үе шатанд төрийн болон хувийн хэвшлийн аль алиных нь оролцоо давамгайлсан гэж үзэн эхний ээлжид төрийн оролцоо давамгайлсан венчур капиталыг дэмжихэд чиглэжээ. Судалгааны үр дүнд жижиг, дунд үйлдвэрүүдийн (ЖДҮ) санхүүжилтийн эрэлт хэрэгцээ их байгааг тодруулж арилжааны банкны зээлийн хүртээмж хязгаарлагдмал, өндөр хүүтэй, хатуу шаардлага, хугацаа богино, барьцаа хөрөнгийн дутагдал зэрэг хүндрэл бэрхшээлийг даван туулах нь нэн чухал шаардлагатай байгааг онцолжээ. Тиймээс ЖДҮ-ийн хөгжлийг венчур капиталын санхүүжилтээр дэмжих нь зайлшгүй чухал гэж үзжээ (Н.Амарсайхан, 2016).

С.Гэрэлчимэг (2018) судалгаагаараа ЖДҮ-үүдэд тулгарч буй санхүүжилтийн бэрхшээлийг судалж, шийдвэрлэх боломжуудыг санал болгожээ. Судалгааны хүрээнд хийсэн ЖДҮ-ийн түүвэр судалгааны үр дүнд тулгарч буй бэрхшээлүүдийн дотроос барьцаа хөрөнгийн асуудал хамгийн том хүндрэл байгааг тогтоожээ. Тодруулбал, банкнууд зээлийн үндсэн шалгуур болох бизнесийн төсөл, орж ирэх мөнгөн урсгал бус барьцаа хөрөнгийн шаардлагыг урьтал болгож байгаа нь манай улсад санхүүгийн зээлийн тогтсон туршлага дутмаг байгааг харуулж байна. Энэхүү судалгаа нь мөн ЖДҮ-ийг дэмжих зорилготой Хятадын төрийн батлан даалтын фондын системийг онцолж байсан бөгөөд төрийн оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй гэж үзжээ. Зөвлөмжид татварыг бууруулах, төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, шинэлэг технологи нэвтрүүлэх зэрэг бүс нутаг бүрийн өвөрмөц онцлог, нөөцөд тохирсон экспортын стратегийн бодлогыг баримтлах хэрэгтэй гэж үзжээ. Судалгаанаас гол анхаарах зүйл бол ЖДҮ-ийн зээлийн хүүг тухайн салбарын онцлогт тулгуурлан тогтоох санал гаргасан бөгөөд тухайлбал, үйлдвэрлэгчдэд 5-10%, үйлчилгээ ба худалдааны салбарт 10-15% байхаар санал болгож байна (С.Гэрэлчимэг, 2018).

Б.Анужин (2019) судалгаандаа хөгжиж буй болон хөгжингүй орнуудын туршлага, санхүүжилтийн хэлбэрүүд, нөлөөлөх хүчин зүйлс, ЖДҮ эрхлэгчдэд олгож буй санхүүжилт, түүний үр ашгийг нэмэгдүүлэх боломжийн талаар авч үзсэн байна. Манай улсад ЖДҮ-ийг дэмжих зорилгоор арилжааны банкнуудаар дамжуулан олгосон их

хэмжээний хөнгөлөлттэй зээл, тусламжийн үр дүнд ажлын байр бий болгох, дотоодын үйлдвэрлэл мэдэгдэхүйц өссөн хэдий ч санхүүжилтийн асуудал байсаар байна. Энэ хүндрэл нь хоёр шалтгаантай. Нэгдүгээрт, арилжааны банкны аргачлалтай уялдуулан процедурын, нөхцөлт, шалгуурт суурилсан зээлийн зарцуулалт, зээлийн ашиглалт, үр ашигт тавих хяналт хангалтгүй. Хоёрдугаарт, хөнгөлөлттэй зээл байхгүй, зах зээлийн багтаамж хязгаарлагдмал, хөрөнгийн зах зээл хөгжөөгүй, инфляц, улс төрийн тогтворгүй байдал, гадаадын хөрөнгө оруулалтыг татах боломж хязгаарлагдмал, макро эдийн засгийн хямралд өртөмтгий, банкнуудын зээлдэгчийг зээлийн чадвараар нь үнэлэх, сонгох аргачлал хангалтгүй байгаа нь ЖДҮ эрхлэгчдэд учирч буй санхүүжилтийн бэрхшээлийг улам хурцатгаж байна (Б.Анужин, 2019).

Н.Сайнсанаа, С.Хандмаа, Б.Тэмүлүн (2019) нарын судалгаанд жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нь компанийн засаглалыг хэрэгжүүлэхийн давуу талыг тодорхойлж, үүнд олон улсын туршлагыг гүнзгийрүүлэн судалжээ. Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүд дунд засаглалтай байсан нь дараагийн өсөлтийн бат бөх суурийг тавих боломжтой гэж үзжээ. Иймээс ЖДҮ-д зориулсан компанийн засаглалыг бий болгох нь хөгжлийг хурдасгах, эдгээр компаниудтай холбоотой хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулах арга хэрэгсэл гэж үзэж байна (Н.Сайнсанаа, С.Хандмаа, Б.Тэмүлүн, 2019).

М. Гэрэлтуяа (2020) судалгааны ажил нь ЖДҮ-ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломж, стратегийг тодорхойлохыг зорьжээ. Судлаач анхдагч болон хоёрдогч эх сурвалжийг ашиглан эмпирик судалгаа хийжээ. Анхдагч мэдээллийн хүрээнд ЖДҮ-ийн санхүүжилтийн нөхцөл байдлыг нягтлан судалж, санхүүжилтийн шалгуурыг хангаагүй, барьцаа хөрөнгийн хүрэлцээ муу, мэдээллийн хомс байдал, өндөр хүүтэй, богино хугацаатай зээлийн тархалт зэрэг тодорхойлогч хүчин зүйлсийг тодорхойлсон. Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд судлаач гурван боломжит шийдлийг санал болгосон. Эхнийх нь "Хур" системээр дамжуулан цахим банкны үйлчилгээг хөгжүүлэх. Хоёр дахь нь хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгохыг санал болгож байгаа бол гурав дахь нь шинэ платформ дээр crowdfunding санхүүжилтийг оновчтой шийдэл болгон ашиглахыг зөвлөж байна (М. Гэрэлтуяа, 2020).

Б.Цэнгэл (2020) судалгаа нь ЖДҮ-ийн санхүүжилтийн арга хэрэгслийн талаар судалж цаашдын санхүүжилтийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлохыг зорьжээ. ЖДҮ эрхлэгчдэд тулгардаг гол асуудал бол барьцаа хөрөнгийн хангалтгүй байдал юм. Судалгаандаа факторинг үйлчилгээний талаар нарийвчлан авч үзжээ. Үр дүнд хөнгөлөлттэй зээл, факторинг хэрэгслийн үнэ арилжааны банкнуудынхаас хоёр дахин бага өртөгтэй байгааг тогтоожээ. Тиймээс ЖДҮ-ийн санхүүжилтэд факторингийн үйлчилгээ хамгийн боломжит санхүүгийн хувилбар гэж үзжээ (Б.Цэнгэл, 2020).

#### **1.2.1.2 Олон улсад судлагдсан байдал**

Shinozaki, S (2012) судалгаанд 2010 онд Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг (ЖАЙКА), Индонезийн хөрөнгийн зах зээл, санхүүгийн байгууллагуудын хяналтын агентлаг (Варерам-ЛК) нь Аж үйлдвэрийн яам, Хоршоолол, ЖДҮ-ийн яам, Төв Жава мужийн засаг захиргаа, тэргүүлэгч нартай хамтран Индонезийн венчур капиталын "PT Bahana Artha Ventura" компани Индонез даяар 622 бичил, жижиг, дунд үйлдвэр

(ЖДҮ)-ийн түүвэр судалгааг хийжээ. Судалгааны үр дүнгээс үзэхэд судалгаанд оролцогчдын тал орчим хувь нь (54.2%) банканд санхүүжилт авахаар хандсан бол үлдсэний тал хувь нь өөрийн хөрөнгө, дөрөвний нэг нь (25.1%) гэр бүл, хамаатан садан, найз нөхдөөсөө зээл авч ирээдүйн санхүүжилтээ авсан байна. Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид банк (64.5%), банк бус (33.8%), венчур капиталын компаниуд (31.4%) зэрэг албан ёсны санхүүгийн байгууллагуудаас цаашид санхүүжилт авахыг хүссэн байжээ. Мөн ЖДҮ-үүд өөрийн хөрөнгө (20.9%) болон албан бус сектор буюу хувийн зээлээс (7.2%) хамааралтай байдлаа багасгахыг хүсжээ (Shinozaki, 2012).

Guercio, M. Belen (2020) судалгааны зорилго болох ЖДҮ-ийн санхүүжилтийн хүртээмжийг тодорхойлох хүчин зүйлсийг судлахаар европын 37 оронд үйл ажиллагаа явуулж буй 27811 компанийн дата мэдээлэл дээр судалгааны ажил хийгдсэн. Судалгааны үр дүнд пүүсийн үйл ажиллагаа томрох тусам найдвартай санхүүгийн эх үүсвэрийг илүүд үздэг ба банкнаас зээл авах хандлага нэмэгдэж байна. Харин жижиг пүүсүүд банкнаас зээл авахад хүндрэлтэй байдаг гол шалтгаан нь санхүүгийн тайлан гаргадаггүйгээс болдог байна. Судалгааны үр дүнгээс ЗГ-ын дэмжлэгтэйгээр арилжааны банкнаас зээл гаргах нь асуудлыг шийдэх бодлогын арга хэмжээ болно гэж дүгнэжээ (Guercio, M. Belen etc, 2020).

Small and medium enterprises financing (2017) судалгаанд банкны систем давамгайлсан улс орнууд ЖДҮ-ийг санхүүжүүлэх боломж хязгаарлагдмал байдаг ба банкнаас зээл авах нь хямралын үед эмзэг байдлыг нэмэгдүүлдэг. Иймээс уламжлалт банкны зээлээс илүү өөр санхүүжилтийн аргуудыг тодорхойлохыг зорьсон. Шинжилгээний үр дүнд корпорацийн бонд гэхээсээ илүү ЖДБ-ийн бондын зах зээлийг бий болгох нь илүү ашигтай хувилбар гэж үзжээ. Мөн тус улсын хөрөнгийн зах зээлийн санхүүжилтийг зохицуулах эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай гэж үзсэн байна (United Nations Economic and Social Commission for Asia and the Pacific, 2017).

Research on the Causes and Countermeasures of Financing Difficulties of Small and Medium-sized Enterprises (2019) судалгаа нь Хятадын ЖДҮ-ийн санхүүжилтийн хэрэгслүүдийг судалж, санхүүжилтийн бэрхшээлийг шийдэх шинэлэг шийдлүүдийг санал болгох зорилготой хийгджээ. Судалгаанд банкнуудын үзүүлж буй санхүүгийн дэмжлэг хязгаарлагдмал, ЖДҮ эрхлэгчид банкны салбарын эрсдэл даах чадвар, хөрөнгийн дутмаг байдал зэргээс үүдэн санхүүжилтийн хэрэгцээгээ хангахад хүндрэлтэй тулгардаг болохыг онцолжээ. ЖДҮ-ийн санхүүжилтийн гол суваг нь банкны зээл бөгөөд зээлийн шинэлэг бизнесийг хөгжүүлэх бодлогын хүрээнд 2008 оноос хойш зээлийн бодлогыг чангатгаснаар ЖДҮ-ийн санхүүжилтийн хүндрэлтэй тулгараад байна. Түүнчлэн зээлийн батлан даалтын байгууллагуудын үйл ажиллагаа нь хангалтгүй байдал, хууль эрх зүйн орчин, эрсдэлийн хяналтын тогтолцоо дутмаг байгаа нь ЖДҮ-ийг санхүүжүүлэхэд хүндрэл учруулж байна. Үр дүнд Хятад улс ЖДҮ-ийн өсөлт хөгжлийг дэмжихийн тулд хууль эрх зүйн орчныг сайжруулах, үр дүнтэй хэрэгжүүлэх, олон төрлийн санхүүжилтийн сувгуудыг бий болгох шаардлагатай гэж үзжээ (Cheng, 2019).



## 1.2.2 Зээлийн батлан даалтын судлагдсан байдал

Манай улсад зээлийн батлан даалтын тогтолцоо үүссэнээс хойш 10 гаруй жилийн хугацаа өнгөрсөн ба энэ хугацаанд зээлийн батлан даалтын сан үйл ажиллагаагаа өргөжүүлэх болон батлан даалттай холбоотой статистик судалгааг түлхүү хийж иржээ. Гэвч жижиг, дунд үйлдвэрийн санхүүжилтийн хүртээмж, барьцаа хөрөнгийн асуудлын хүрээнд зээлийн батлан даалтын ач холбогдол, гүйцэтгэх үүргийг нарийн судлаагүй бөгөөд дотоодод хийгдсэн судалгаа хомс байна. Иймээс зээлийн батлан даалтын тогтолцооны олон улсад хийгдсэн судалгааг тоймлон авч үзлээ.

The role of SMEs in Asia and their difficulties in accessing finance (2018) судалгаагаар ЖДҮ нь Азийн эдийн засгийн тулгуур багана бөгөөд бүс нутгийн нийт бизнес эрхлэгчдийн 96 гаруй хувийг эзэлж, нийт ажил эрхлэлтийн гуравны хоёрыг бүрдүүлж байна. Азийн улс орнуудын эдийн засаг нь ЖДҮ-ийн өсөлтөөс хамаарал өндөр байна. Гэвч ЖДҮ-үүдэд санхүүжилтийн бэрхшээл түгээмэл тулгарч байгаа бөгөөд голчлон санхүүжилт олгогчид болон санхүүжилт хүсэгчдийн хоорондох тэгш бус мэдээлэл, гүйлгээний зардал өндөр байдагтай холбоотой байна. Эдгээр сорилтууд нь барьцаа хөрөнгийг өсгөж, зээлийн хүүг нэмэгдүүлж улмаар ЖДҮ-ийн өсөлтийг хязгаарлаж байна. Азийн ихэнх орнууд банк давамгайлсан эдийн засагтай улс учраас хөрөнгийн зах зээлийн санхүүжилт нь ЖДҮ-ийн хувьд бодитой хувилбар биш юм. Тиймээс банкнаас ЖДҮ-д олгох зээлийг хөнгөвчлөх шийдлүүдийг эрэлхийлэх хэрэгтэй. Судалгаанд ЖДҮ эрхлэгчдэд тулгарч буй санхүүгийн бэрхшээлийг тодорхойлж, тэдгээрийг бууруулах боломжийг санал болгожээ. Санал болгож буй интервенцүүд нь ЖДҮ-д тохирсон зээлийн мэдээллийн дэд бүтцийг бий болгох, мэдээллийн тэгш бус байдлыг арилгах, зээлийн үнэлгээний аргачлалыг хэрэгжүүлэх, ЖДҮ-ийн барьцаа хөрөнгийн асуудлыг хөнгөвчлөх санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн тогтвортой зээлийн батлан даалтын тогтолцоог бий болгох гэжээ (Asian Development Bank, 2018).

Developing the Capital Market to Widen and Diversify SME Financing: The Korean Experience (2008) судалгаанд БНСУ-ын засгийн газар эдийн засгийн өсөлтийг хурдасгах, ялангуяа хямралын үед ажилгүйдлийг бууруулах зорилгоор шинэ бизнесүүдийг дэмжиж, ЖДҮ-үүдийг дэмжсээр ирсэн. Шууд болон шууд бус дэмжлэг үзүүлэх олон арга хэмжээний дотроос зээлийн батлан даалтын тогтолцоо нь эдийн засгийн бодлогын зорилтод хүрэх хамгийн чухал хэрэгслийн нэг гэж үзжээ. Тухайлбал, 1990-ээд оны сүүлч, ялангуяа 2000-аад оны эхэн үед венчур бизнесүүд уналтад орсон эдийн засгийн хямралын үед жижиг, дунд үйлдвэрүүдэд хөрөнгийн зах зээлээс шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүрдүүлэхэд зээлийн батлан даалтын тогтолцоо чухал үүрэг гүйцэтгэсэн. Энэ үед банкууд ЖДҮ-ийн зээлийг эрсдэх магадлал өндөр гэж үзэж, ЖДҮ-д зээл олгохоос татгалзаж байсан нь зээлийн батлан даалтын хэмжээ маш хурдацтай өсөхөд нөлөөлжээ. Ийм хандлагатай байгаагийн нэг шалтгаан нь ЖДҮ-ийн дампуурлын түвшин өндөр, барьцаа хөрөнгө, ялангуяа венчур бизнес, шинэ технологи зэрэг төрөлхийн өндөр эрсдэлтэй холбоотой байжээ. Энэхүү судалгаанд ЖДҮ-ийн мэдээллийн санг ашиглан ЖДҮ-ийн гүйцэтгэл, өсөлтөд үзүүлэх зээлийн баталгааны нөлөөг үнэлдэг ба бичил бизнесийн түвшний мэдээллийг орхигдуулалгүй авч үздэгээрээ ижил төстэй

судалгаануудаас ялгаатай. Судалгааны үр дүнд пүүсүүдийн хэмжээ, аж үйлдвэрийн салбараар ялган зээлийн баталгааны бодлогыг хэрэгжүүлсэн нь ЖДҮ-ийн санхүүгийн эх үүсвэр олоход тулгарч буй хүндрэлийг арилгах, хөдөлмөр эрхлэлтийг тогтворжуулах ЗГ-ын зорилгод нийцсэн ба эерэг үр дүнтэй байжээ (Jae-Ha Park, Byung-Chul Lim, Jung-Han Koo, 2008).

Credit Guarantee Schemes for SME lending in Central, Eastern and South-Eastern Europe (2014) судалгаанд баруун Европын орнуудад ЖДҮ-д тулгарч буй санхүүжилтийн хүндрэлийг шийдвэрлэхэд зээлийн батлан даалтын санг ашиглах нь түгээмэл байна. Ялангуяа санхүүгийн хямралын дараах хүнд үед ЗБДС нь ЖДҮ эрхлэгч ААН-ийг эргээд хөл дээр нь босгох, ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэхэд чиглэсэн төрийн бодлогын түгээмэл ашиглагддаг арга хэрэгсэл байсаар иржээ. Баруун Европт зээлийн батлан даалтын тогтолцоо маш сайн хөгжсөн бөгөөд Итали, Португали улсууд уг тогтолцооны эдийн засагт үзүүлсэн эерэг нөлөөний цар хүрээгээрээ тэргүүлдэг. Эдгээр сангууд нь засгийн газар болон ЕХ-ны баталгаагаар эрсдэлийг удирдах үүрэгтэй ба төрийн өмчийн болон ашгийн бус үйл ажиллагаатай бөгөөд баталгаа гаргах замаар банкнуудын барьцаа хөрөнгийн хүндрэлийг бууруулах зорилготойгоор дотооддоо үйл ажиллагаа явуулдаг. Судалгааны үр дүнд хил дамнасан зээлийн баталгаа гаргах боломж байгааг харуулж байна. Үүнд баруун европын үндэстэн дамнасан санхүүгийн байгууллагуудыг зээлийн батлан даалтад нэгтгэх ба тэд жижиг, дунд үйлдвэрийн санхүүжилтийн хуваарилалтын үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг хийж, эрсдэлийг ЕХ-оор дамжуулан удирдах боломжтой (Vienna Initiative Working Group, 2014).

Japanese SMEs and the credit guarantee system after the global financial crisis (2015) судалгаанд Японы төрийн зээлийн батлан даалтын тогтолцоог товч тоймлон харуулж, дэлхийн санхүүгийн хямралын үед ямар үүрэг гүйцэтгэсэн талаар дүн шинжилгээ хийжээ. Судлаач хямралд ихээхэн нэрвэгдсэн Аичи мужийн жижиг, дунд үйлдвэрүүдийг хамруулан Аичи-кен зээлийн батлан даалтын корпорацитай хамтран асуулга ашиглан судалгаа явуулжээ. Судалгааны үр дүнд уг ЗБДТ нь эдийн засгийн уналтаас сэргийлэх үр дүнтэй систем болохыг онцолжээ. ЗБДТ нь ЖДҮ эрхлэгчдэд маш чухал нөлөөтэй байсан тул бараг бүх ЖДҮ-үүд уг системийг хямралын дараач өөрчлөхгүй байхыг хүсч байна. Гэвч уг системийн ЖДҮ-үүдэд үзүүлж буй өгөөмөр байдал нь Японы засгийн газарт санхүүгийн ихээхэн дарамт учруулж, зорилтот ЖДҮ-ийн санхүүгийн хүртээмж муудсан ба банкнуудын зээлийн үр ашигт байдал мууджээ. Иймээс хөтөлбөрийн хамрах хүрээ, зээлийн баталгааны хувь хэмжээг нарийсгах зэрэг шинэчлэл зайлшгүй шаардлагатай болсон байна (Yamori, 2015).

## II БҮЛЭГ. ОНОЛЫН УХАГДАХУУН

### 2.1 Жижиг, дунд үйлдвэрийн үүсэл хөгжил, ойлголт

Жижиг, дунд бизнесийн түүхэн гарал үүслийг дэлхийн анхны соёл иргэншилтэй холбож үзэж болно. Эрт дээр үед хүмүүс газар тариалан, ан агнуур, загас агнуур, худалдаа зэрэг хэрэгцээгээ хангахын тулд янз бүрийн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг байв. Нийгэм улам бүр ээдрээтэй болохын хэрээр эдийн засгийн үйл ажиллагааны шинэ хэлбэрүүд бий болж үүнийг дагаад жижиг, дунд бизнес хөгжиж байсан. Жижиг, дунд бизнесийн тухай хамгийн эртний бичмэл баримтууд нь 4000 жилийн тэртээгээс эхтэй ба одоогийн Иракт байрладаг эртний Шумераас гаралтай бөгөөд вааран эдлэл, нэхмэл эдлэл зэрэг бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг жижиг бизнесүүд байсныг баримтжуулдаг. Жижиг, дунд бизнесийн анхны хэлбэрүүдийн нэг нь бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдаалах явдал байв. Египет, Грек, Ром зэрэг эртний соёл иргэншилд гар урчууд, нэхмэл эдлэлээс эхлээд төмөр хийц, гоёл чимэглэл хүртэл өргөн хүрээний бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг байсан ба эдгээр барааг орон нутагт болон хол зайд худалдаалж байсан нь бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагаанд оролцдог жижиг, дунд бизнесүүдийн өсөлтийг бий болгосон.

Жижиг, дунд бизнес хөгжихөд нөлөөлсөн бас нэг хүчин зүйл бол банк санхүү бий болсон явдал юм. Эрт дээр үед мөнгө хүүлэгчид, банкирууд хувь хүн, аж ахуйн нэгжүүдэд зээл олгодог байсан ба зээл олгох, зээлэх нь түгээмэл байжээ. Эдгээр зээлийг ихэвчлэн худалдаа, арилжааг санхүүжүүлэхэд зарцуулж байсан ба энэ нь жижиг, дунд бизнесийг хөгжихөд түлхэц болсон. Жижиг, дунд бизнесийг хөгжүүлэхэд 18-19-р зууны аж үйлдвэрийн хувьсгал чухал нөлөө үзүүлсэн. Шинэ технологи, үйлдвэрлэлийн үйл явц хөгжихийн хэрээр жижиг, дунд бизнесүүд бараа, үйлчилгээ илүү үр ашигтай, өргөн цар хүрээтэй үйлдвэрлэх боломжтой болсон нь нэхмэл эдлэл, ган, тээвэр зэрэг салбарын хөгжилд эергээр нөлөөлсөн. (Г.Цог-Өрнөх, 2001) Өнөөдөр жижиг, дунд бизнесүүд дэлхийн эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэсээр байгаа бөгөөд дэлхийн өнцөг булан бүрт бараа, үйлчилгээ үйлдвэрлэх, хүмүүсийг ажлын байраар хангахад хувь нэмрээ оруулсаар байна.

Харин манай улсын ЖДҮ нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэн үеэс буюу нийгэм, эдийн засгийн харилцаанд зарчмын өөрчлөлт гарч, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд олноор бий болсноор хөгжих үндэс тавигджээ. Монголд арилжааны банкнууд 1990-ээд оны эхэн үеэс буюу социализм задран унасны дараа зах зээлийн эдийн засагт шилжсэнээр бизнесийн зээл олгож эхэлсэн. Тухайлбал Монгол Улсад 1991 онд хамгийн анхны арилжааны банкнууд болох Худалдаа хөгжлийн банк (ХХБ), Голomt банкнууд байгуулагдсан. Улмаар эдгээр банкнууд нь 2000-аад оны эхэн үеэс жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зээл олгож эхэлсэн. Үүнээс өмнө Монголын арилжааны банкнуудын ихэнх зээл томоохон корпорацууд болон гадаадын хөрөнгө оруулагчдад төвлөрч байв. Харин Монгол Улсад ЖДҮ-ийг хөгжүүлэхэд төр, олон улсын байгууллагууд түлхүү анхаарч эхэлснээр арилжааны банкнууд ч энэ салбарт үзүүлэх үйлчилгээгээ өргөжүүлж эхэлжээ. Манай орон анх 1993 онд үйлдвэрийг хөгжүүлэх яаманд жижиг, дунд үйлдвэрийн хэлтсийг байгуулснаар тус салбарыг албан

ёсоор хөгжүүлэх суурь тавигдсан. Улмаар 1999-2003 онд анх удаа ЖДҮ-г хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж байв. Уг хөтөлбөр амжилттай хэрэгжсэний дараа 2005 оноос хойших жилүүдэд холбогдох байгууллагууд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрүүдийг тууштай хэрэгжүүлсээр иржээ. Хамгийн сүүлд хэрэгжүүлсэн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр нь хоёрдугаар үе шатандаа хэрэгжиж байгаа ба ажлын байрыг нэмэгдүүлэх хүлээлттэй байна.

Зураг 2.1 Монгол улсын ЖДҮ-ийн салбарын хөгжлийн түүх



Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

ЖДҮ-ийн салбарыг тодорхойлогч жижиг бизнес /small business/, жижиг үйлдвэр /small industry/, жижиг, дунд үйлдвэр /small and medium sized enterprise / зэрэг ойлголтууд чанарын ялгааг илтгэхгүй бөгөөд тэдгээрийн мөн чанар нь нэг. Эдгээр нэр томъёоноос манай улсад жижиг, дунд бизнес гэсэн ойлголтыг түлхүү хэрэглэж байна (С.Гэрэлчимэг, 2018).

**Жижиг, дунд үйлдвэрлэл:** Монгол улсын хувьд жижиг, дунд үйлдвэрлэл гэдэг нь ажиллах хүчний болон үйлдвэрлэлийн цар хүрээгээр авсаархан, дотоод зах зээл рүү чиглэсэн, богино хугацаанд зардлаа нөхөж чаддаг, хөрөнгө мөнгө бага шаарддаг, өндөр бүтээмжтэй, үйлдвэрлэлийн уян хатан технологитой, зэх зээлд өрсөлдөх чадвар бүхий бизнесийг хэлнэ. ([www.sme.gov.mn](http://www.sme.gov.mn), 2023)

**Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч:** Компани, хоршоо, нөхөрлөлийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг 200 хүртэл ажилтантай, жилийн 2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг хэлнэ. ([www.sme.gov.mn](http://www.sme.gov.mn), 2023)

Монгол улсын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2019 оны 6-р сарын 6-ны өдөр баталсан бөгөөд үүнд бичил, жижиг, дунд үйлдвэрүүдийн нэгдсэн тодорхойлолтыг шинэчлэн хуульчилсан. Хуульд аж ахуйн нэгжийг бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид гэж дараах 3 бүлэгт хуваажээ.

## Хүснэгт 2.1 Монгол улсын ЖДҮ-ийн ангилал

Ангилал	Ажилчдын тоо	Жилийн борлуулалтын орлого
Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	10 хүртэл ажилтантай	300.0 сая төгрөг (~100,000 евро)
Жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	10-50 хүртэл ажилтантай	300.0 сая-1.0 тэрбум төгрөг (~333,000 евро)
Дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	50-200 хүртэл ажилтантай	1.0-2.5 тэрбум төгрөг (~745,000 евро)

Эх сурвалж: [Жижиг дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хууль](#)

Харин ЖДҮ-ийн тодорхойлолт нь нийгэм, эдийн засгийн өвөрмөц нөхцөл байдлаас шалтгаалан улс орон бүрд харилцан адилгүй байдаг. Дэлхийн банк ЖДҮ-ийг ангилахдаа ажилчдын тоо, борлуулалтын орлогод үндэслэн ангилж байна.

## Хүснэгт 2.2 Дэлхийн банкны ЖДҮ-ийн ангилал

Ангилал	Ажилчдын тоо	Жилийн борлуулалтын орлого
Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	10 хүртэл ажилтантай	100.0 хүртэлх ам.дол
Жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	10-50 хүртэл ажилтантай	100.0-3,000.0 ам.дол
Дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	50-300 хүртэл ажилтантай	3,000.0-15,000.0 ам.дол

Эх сурвалж: *Жижиг дунд үйлдвэрлэлийн ангилал. Дэлхийн банк 2011*


## 2.2 Зээлийн батлан даалтын тогтолцооны үүсэл хөгжил, загварууд

Зээлийн батлан даалтын тогтолцоо нь банк болон банк бус санхүүгийн байгууллага гэх мэт зээлдүүлэгчид зээлийн чадвар, барьцаа хөрөнгийн дутагдал болон бусад хүчин зүйлээс шалтгаалан санхүүжилт авахад хүндрэлтэй байгаа зээлдэгчдэд зээл олгоход чиглэсэн санхүүгийн механизм ба зээлдүүлэгчид даатгалын хэлбэрийг олгодог бөгөөд зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд гуравдагч талын байгууллага зээлийн тодорхой хэсгийг төлдөг.

1840-өөд онд Европт барьцаа хөрөнгийн хүрэлцээгүйгээс болж арилжааны банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авахад бэрхшээлтэй тулгарсан жижиг бизнес эрхлэгчид нэгэндээ туслах зорилгоор зээлийн батлан даалтын хоршоо байгуулахаар нэгдсэн нь анхны зээлийн батлан даалтын байгууллага байжээ. Энэ үед хамгийн түгээмэл ашиглагдаж байсан зээлийн баталгааны схем нь Италийн зээлийн батлан даалтын хоршооны тогтолцоо юм. Уг схемд зээл авах сонирхолтой, шаардлагатай жижиг, дунд үйлдвэрүүд хөрөнгөө нийлүүлэн, нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээрээ өмчлөх эрхтэйгээр зээлийн батлан даалтын хоршоо байгуулж, хоршоонд харьяалалтай ЖДҮ банкнаас зээл авахад тус хоршоо нь баталгаа үзүүлэх ба засгийн газар хоршоонд хандив үзүүлэх өвөрмөц бүтэцтэй байжээ. Түүхэн хувьслын явцад зарим хоршоод Европын эдийн засагт томоохон нөлөө үзүүлсээр санхүүгийн институт болон хөгжсөн ба "Касса

Депозити э Престити" зээлийн баталгааны байгууллага нь үүний томоохон төлөөлөл болж байна (Mulazzani, 2004).

Зураг 2.2 Итали улсын зээлийн батлан даалтын хоршооны схем, 1840 оны үе



Эх сурвалж: (Linda Deelen, 2004)

Дэлхийн 2-р дайны дараа 1950-1960-аад оны үед төрөөс баталгаажсан зээлийн батлан даалтын сангууд бий болж, эдийн засгийг сэргээх хүчин чармайлтад идэвхтэй оролцож байв. Тухайн үед байгуулагдсан сангуудын зарим нь хувийн хэвшлийн өмчлөлтэй байсан тул төр тэдэнд давхар батлан даалтын хэлбэрээр дэмжлэг үзүүлж байсан. Үүний нэг жишээ нь Германы зээлийн батлан даалтын банкнууд ба тэд өнөөдөр хамгийн эерэг үр дүнг гаргажээ. Германы зээлийн батлан даалтын банкнууд 1992-2002 оны хооронд улс орныхоо ДНБ-ий үйлдвэрлэлийг 3.6 тэрбум еврогоор нэмэгдүүлж, шинээр 23000 ажлын байрыг бий болгон, бараа, гүйлгээ, хөрөнгийн татвар хэлбэрээр улсын төсөвт 830 сая еврогийн орлогыг бүрдүүлсэн байна (Guy Selbherr, 2009).


Зураг 2.3 Герман улсын зээлийн батлан даалтын банкны схем, 1950-1960 оны үе



Эх сурвалж: (Levitsky, 2006)

Энэ үед төрийн өмчлөл бүхий сангууд бас байгуулагдаж одоог хүртэл үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна. Жишээлбэл, Японы зээлийн батлан даалтын сан, Солонгосын зээлийн батлан даалтын сан зэргийг дурдаж болно.

Зураг 2.4 Япон улсын зээлийн батлан даалтын схем



Эх сурвалж: Japan Federation of Credit Guarantee Corporations. 2014.

Улмаар 1970-1980-аад оны үед хөгжиж буй орнуудын донор байгууллагуудын санаачилгаар төрөөс дэмжлэг авч зээлийн баталгааны санг бий болгох хөдөлгөөн өрнөсөн байна. Харамсалтай нь зах зээлийн судалгаа дутмаг, дотоодын хувийн хэвшил сонирхоогүй зэргээс болж ихэнх ажлууд гацаж сангууд дампуурч байжээ. Хөгжиж буй орнуудад зориулсан зээлийн батлан даалтын сангууд үндсэндээ чанаргүй зээлээс болж алдагдал хүлээсэн, эрсдэлийг зөв тооцолгүйгээр тодорхой бүлэгт зээл олгохыг ялгаварлан дэмжсэн буруу шийдвэрээс үүдэн сангийн хөрөнгө шавхагдсан байна. Мөн зээлийн батлан даалтын үйлчилгээ мэдээллийн тэгш бус байдлыг багасгах гэхээсээ илүү нэмэгдүүлэх хандлагатай гэж олон судлаачид шүүмжилж байна. Үүний үр дүнд зээлдэгч болон зээлдүүлэгчдийн дунд залилан мэхлэх гэмт хэргийн тархалт нэмэгдэж, хөгжлийн байгууллагууд зээлийн батлан даалтын хөтөлбөрийн үр нөлөөг дахин дахин турших сонирхол буурсан байна.

Харин 1990 оноос хойш шилжилтийн эдийн засагтай улс орнууд зээлийн батлан даалтын санг донор байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн санаачилгаар төрийн

дэмжлэгтэйгээр байгуулсан нь амжилттай хэрэгжиж байна. Энэ үед байгуулагдсан сангуудын зарим нь төр, хувийн хэвшлийн хамтарсан өмчлөл бүхий сангууд байгаа бол зарим сан нь 100 хувь төрийн өмчлөлтэйгөөр байгуулагджээ. Зээлийн батлан даалтын тогтолцооны түүхэн хөгжил нь эдийн засгийн нөхцөл байдал, бодлогын зорилтод нийцүүлэн тасралтгүй хувьсан өөрчлөгдөж байдаг.

### **Зээлийн батлан даалтын харьцаа**

Зээлийн батлан даагч байгууллагын хувьд зээлийн батлан даалтын зохистой харьцааг тогтоох нь урт хугацааны үйл ажиллагаа, тогтвортой байдлыг хангахад нэн чухал байдаг. Зээлийн батлан даалтын харьцаа нь зээлийг батлан даагч тал болон зээлийн баталгааг эрэлхийлж буй ЖДҮ-ийн аль алинд нь эрсдэл ба өгөөжийн тэнцвэрт байдалд нөлөөлдөг учраас уг харьцааг оновчтой тогтоох нь чухал ач холбогдолтой.

Зээлийн батлан даалтын харьцаа (CGR) нь төрийн байгууллага, зээлийн батлан даалтын сан зэрэг гуравдагч этгээдийн батлан даагчаар баталгаажсан зээлийн хувийг илэрхийлдэг хэмжүүр юм. Өөрөөр батлан даагч нь зээл авагчийн зээлээ төлөхгүй байх эрсдэлийг ямар түвшинд хүлээж болох дээд хувийг илэрхийлдэг.

$$\text{Зээлийн батлан даалтын харьцаа (CGR)} = \frac{\text{Батлан даасан мөнгөн дүн}}{\text{Зээлийн нийт мөнгөн дүн}}$$

Нэг талаас зээлийн батлан даалтын харьцаа өндөр буюу зээлийн батлан даагч тал зээлийн ихэнх хувийг батлан дааж байгаа нь ЖДҮ-ийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, зээл авсан ЖДҮ-ийн эрсдэлийг бууруулдаг хэдий ч илүү эрсдэлтэй зээл олгох хандлагатай байдаг. Гэхдээ бизнес эрхлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд тустай. Нөгөөтгээгүүр, зээлийн батлан даалтын харьцаа өндөр байвал зээлийн батлан даагч талын эрсдэлийг нэмэгдүүлдэг ба батлан даасан зээл эрсэдсэн тохиолдолд санхүүгийн алдагдал хүлээж улмаар ЖДҮ-үүдэд үргэлжлүүлэн баталгаа гаргах боломжгүй болно. Эсрэгээр, зээлийн батлан даалтын харьцаа хэт бага байвал зээлийн батлан даалтын байгууллага нь ЖДҮ-ийн зээлийн хүртээмжийг дэмжих үүргээ биелүүлж чадахгүй, улмаар эдийн засгийн үр ашиггүй болно. Харин зээлийн баталгаа гаргах хүсэлтэй ЖДҮ эрхлэгчдийн хувьд зээлийн батлан даалтын харьцаа нь зээлийн өртөгт нөлөөлдөг учраас чухал ач холбогдолтой. Зээлийн батлан даалтын харьцаа өндөр байх нь ЖДҮ эрхлэгчид зээл авах хүсэл их байдгаас зээлийн хүү, шимтгэлийг өсгөхөд хүргэдэг. Эсрэгээр, зээлийн батлан даалтын харьцаа бага байх нь ЖДҮ эрхлэгчид хүссэн хэмжээний санхүүжилтээ авч чадахгүй, бизнесийн өсөлт удаашрах сул талтай байдаг. Иймээс зээлийн баталгааны харьцааг оновчтой тогтоох нь зээлийн батлан даагч байгууллага, ЖДҮ эрхлэгчид аль алинд нь чухал ач холбогдолтой юм. Уг оновчтой харьцаа нь ЖДҮ-ийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, зээлийн батлан даагч байгууллагын эрсдэл хоорондын тэнцвэрийг хангах ёстой.



### 2.2.1 Зээлийн батлан даалтын оновчтой харьцаанд нөлөөлөгч хүчин зүйлс

**Эдийн засгийн нөхцөл байдал:** Эдийн засгийн өсөлтийн үед зээлдэгчид зээлээ төлөх магадлал өндөр байдаг тул илүү өндөр харьцаатай байх нь тохиромжтой. Эсрэгээр, эдийн засгийн хямралын үед зээлийн эргэн төлөгдөх эрсдэлийг бууруулахын тулд бага харьцаа шаардлагатай байж болно. Гэхдээ улс орнуудад харилцан адилгүй зохицуулалтыг хийдэг.

**Хууль эрх зүй, зохицуулалтын орчин:** Зээл, батлан даалтын оновчтой харьцаанд төрийн бодлого, зохицуулалт нөлөөлдөг. Жишээлбэл, зохицуулагчид санхүүгийн тогтворгүй байдлын эрсдэлийг бууруулахын тулд барьцаа хөрөнгийн хатуу шаардлага тавьж, эсвэл эдийн засгийн өсөлтийг дэмжих шаардлагыг сулруулдаг.


**Банкны эрсдэлд хандах байдал:** Арилжааны банкнууд зээл олгохдоо эрсдэлд хандах хандлага нь өөр өөр түвшинд байдаг. Зарим банкнууд барьцааны шаардлага багатай зээл олгох хүсэлтэй байдаг бол зарим нь илүү их барьцаа шаарддаг.

**Зээлдэгчийн зээлийн чадвар:** Зээлдэгчдийн зээлийн чадвар нь зээлийн батлан даалтын оновчтой харьцаанд мөн нөлөөлж болно. Зээлийн оноо өндөр, өр орлогын харьцаа багатай зээлдэгчид барьцаа хөрөнгийн шаардлага багатай, зээл авах боломжтой байдаг бол зээлийн оноо багатай зээлдэгчид илүү их барьцаа хөрөнгө шаардлагатай болдог.

**Бизнесийн орчин:** Зээлийн батлан даалтын оновчтой харьцаанд зах зээлийн нөхцөл байдал мөн нөлөөлж болно. Жишээлбэл, хөрвөх чадвар өндөр байгаа үед банкнууд барьцаа хөрөнгийн шаардлага багатай зээл олгох хүсэлтэй байдаг бол хөрвөх чадвар муу үед эрсдэлээ бууруулахын тулд илүү их барьцаа хөрөнгө шаарддаг.

Дээрх хүчин зүйлсийг нэгтгэвэл батлан даалтын оновчтой харьцааг тогтоохын тулд эдийн засгийн өсөлтийг дэмжих болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах хоёрын хоорондын тэнцвэрийг хадгалах шаардлагатай бөгөөд үүнд эдийн засаг, зохицуулалт, зах зээлийн олон хүчин зүйлс нөлөөлж болно.

Зураг 2.5 Батлан даалтын харьцааны ЖДҮ-д үзүүлэх нөлөө ба уг харьцаанд нөлөөлөгч хүчин зүйл



Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

### 2.2.2 Зээлийн батлан даалтын харьцааны эдийн засаг дахь нөлөө

**Зээлийн өртөг:** Батлан даалтын харьцаа өндөр байх нь зээлдүүлэгч батлан даасан зээлдээ итгэх итгэлд нөлөөлдөг, мөн өндөр харьцаа нь бага хүүтэй байх нь ЖДҮ-ийн зээлийн өртгийг бууруулах нөлөөтэй. Нөгөөтээгүүр, баталгааны харьцаа бага байх нь ЖДҮ-ийн зээлийн өртөг нэмэгдэхэд хүргэдэг. Учир нь зээлдүүлэгчид өндөр эрсдэлийг нөхөхийн тулд өндөр хүү ногдуулдаг.

**Зээлдүүлэгчдийн эрсдэл:** Баталгаажуулалтын харьцаа өндөр байх нь зээлдүүлэгчийн эрсдэлийг бууруулдаг. Учир нь тэд төлбөрөө төлөхөөс илүү хамгаалалттай байдаг. Харин эсрэгээр, баталгааны харьцаа бага байх нь зээлдүүлэгчдийн эрсдэлийг нэмэгдүүлдэг, учир нь тэд төлбөрийн чадваргүйгээс хамгаалах хамгаалалт багатай байдаг. Энэ нь ЖДҮ-ийн зээлийн хүртээмж, өртөгт нөлөөлж болзошгүй тул зээлдүүлэгчид өөрсдийн хүлээж буй эрсдэлд тулгуурлан зээлийн үйл ажиллагаагаа өөрчилж болно.

**Зээлийн хүртээмж:** ЖДҮ-д зориулсан баталгааны харьцаа өндөр байх нь зээлдүүлэгчид ЖДҮ-д зээл олгох эрсдэлийг хүлээх чадвар өндөр байх тул зээлдүүлэгчдээс зээл авахад илүү хялбар болгоно. Харин эсрэгээр, баталгааны харьцаа бага байснаар ЖДҮ эрхлэгчид зээл олгохдоо болгоомжтой ханддаг тул зээл авахад бэрхшээлтэй байж болзошгүй юм.

**ЖДҮ-ийн зээлжих чадвар:** Батлан даалтын харьцаа өндөр байх нь ЖДҮ-ийн зээлжих чадварт нөлөөлдөг. Хэрэв ЖДҮ-ийн баталгааны харьцаа өндөр байвал эрсдэл багатай зээлдэгч гэж ойлгож болох бөгөөд энэ нь тэдний зээлийн чадварыг сайжруулж, ирээдүйд бусад төрлийн зээл авахад хялбар болдог. Харин эсрэгээр, баталгааны харьцаа бага байх нь ЖДҮ-ийн зээлийн чадварт сөргөөр нөлөөлж, зээл авахад хүндрэл учруулж болзошгүй юм.

**Эдийн засгийн өсөлт:** Зээлийн хүртээмж нь эдийн засгийн өсөлтийн чухал хүчин зүйл бөгөөд ЖДҮ нь олон орны эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгөгч хүч болдог. ЖДҮ-ийн баталгааны оновчтой харьцааны өөрчлөлт нь ЖДҮ-ийн зээлийн хүртээмж, өртөгт нөлөөлж эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтэд нөлөөлдөг.

## III БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА, АРГАЗҮЙ

### 3.1 Судалгааны дизайн

Судалгааны нэг болон хоёрдугаар хэсэгт тулгуурлан судалгааны дизайн боловсруулав. Шинжилгээний эхний хэсэгт хөгжингүй болон хөгжиж буй зарим орны ЖДҮ-ийн өгөгдөл дээр үндэслэн ЖДҮ-ийн эдийн засаг дахь нөлөөллийн харьцуулсан шинжилгээг хийлээ. Олон улсад ЖДҮ-ийн хөгжлийн түвшнийг тодорхойлохдоо ДНБ, ажлын байранд оруулж буй хувь нэмэр болон ЖДҮ-ийн борлуулалтын орлого, экспортод эзлэх хувь гэсэн дөрвөн үзүүлэлтийг харгалзаж үздэг. Харин хөгжиж буй орны хувьд ЖДҮ-ийн ажлын байранд оруулж буй хувь болон эдийн засагт эзлэх хувийн үзүүлэлтэд ач холбогдол өгч байна (Asian Development Bank, 2022). Энэхүү хоёр үзүүлэлтээр ЖДҮ-ийн эдийн засагт үзүүлэх үр нөлөөг тодорхойлохыг зорьсон.

Хоёр дахь хэсэгт ЖДҮ-ийн өсөлтийг хязгаарлаж буй бэрхшээлүүдийг бизнесийн орчны хүрээнд харьцуулан шинжлэв. Гурав дахь хэсэгт уг бэрхшээлийг шийдвэрлэсэн арга замуудыг судалж, хамгийн үр дүнтэй арга замыг тодорхойллоо.

Дөрөв дэх хэсэгт Монголын ЗБДТ-г Ази, Европын хөгжингүй болон хөгжиж буй зарим орны зээлийн батлан даалтын тогтолцоотой харьцууллаа. Ингэхдээ зээлийн баталгааны загварын бүтэц, үүрэг, давуу сул талыг харьцуулан судалж, одоогийн ЗБДТ-г сайжруулах боломжийг шинжлэв.

Зураг 3.1 Судалгааны дизайн, аналитик хүрээ




Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

### 3.2 Баримт бичгийн судалгааны арга зүй

Баримт бичгийн судалгаа нь тодорхой сэдвийн хүрээнд судалгаа хийхийн тулд өмнө нь хийгдсэн баримт бичиг, судалгааны материал, эрдэм шинжилгээний бүтээл, тухайлбал текст, зураг, аудио буюу төрөл бүрийн хэлбэрийн эх сурвалжийг цуглуулан системчилсэн дүн шинжилгээ хийх арга зүй юм. Энэхүү судалгааны арга нь болсон үйл явдал, соёлын талаар, нийгмийн үзэгдлийг судалж ойлгоход ихэвчлэн ашиглагддаг ба

түүх, нийгмийн шинжлэх ухааны салбарт өргөн хэрэглэгддэг. Харин эдийн засгийн салбарт эдийн засгийн тайлан, бодлогын баримт бичиг, санхүүгийн бүртгэл, түүхэн архив зэрэг баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх замаар чухал мэдээлэл, ойлголтыг нэгтгэж чаддаг ба судлаачид эдийн засгийн чиг хандлага, бодлого тодорхойлоход уг судалгааны аргыг ашигласаар иржээ. Судлаачид баримт бичгийн судалгаанд анхдагч болон хоёрдогч эх сурвалжийг ашигладаг ба анхдагч эх сурвалжууд нь тухайн үйл явдал эсвэл судалж буй хугацаанд бүтээгдсэн захидал, гэрэл зураг гэх мэт эх баримт бичиг, эд өлгийн зүйл байдаг бол хоёрдогч эх сурвалж нь бусад зохиогч, судлаачдын анхан шатны эх сурвалжид хийсэн тайлбар, дүн шинжилгээг хэлдэг. Баримт бичгийн судалгааг хийхэд дараах үе шатуудыг дамждаг.

Зураг 3.2 Баримт бичгийн судалгааны үе шат



Эх сурвалж: (Dyllong, 2007)

- **Эх сурвалжийг тодорхойлох:** Цахим хуудас, дуу дүрсний хэрэгсэл, ном, архивын материал, судалгааны тайлан, эрдэм шинжилгээний өгүүлэл болон бусад холбогдох эх сурвалжийг багтаасан судалгаанд хамаарах баримт бичиг, бүртгэлийн ангилал, төрлийг тодорхойлох.
- **Баримт бичгийг хайж олох:** Холбогдох баримт бичгүүдийг олохын тулд онлайн мэдээллийн сан, номын сан, архив, болон бусад эх сурвалжийг ашиглана. Олсон баримт бичгийн илэрц буюу олдоц, эх сурвалжийг тэмдэглэх.
- **Эх сурвалжийн найдвартай байдлыг үнэлэх:** Баримт бичгийн найдвартай, хазайлтгүй үнэн, судалгаанд хамааралтай эсэхийг тодорхойлж, найдвартай байдлыг үнэлэх.
- **Мэдээллийг задлах:** Унших, үзэх, сонсох замаар баримт бичгүүдийг сайтар шалгаж, судалгааны асуудалтай холбоотой холбогдох мэдээлэл, өгөгдлийг шүүж авна. Шүүсэн мэдээллээ судалгаандаа ашиглахдаа эх сурвалжийг стандартын дагуу зөв иш татаж оруулах .
- **Өгөгдөлд дүн шинжилгээ хийх:** Судалгаанд ашиглагдах загвар, үр дүнг гарган авахын тулд задалсан мэдээллийг ангилах, нэгтгэх болон бусад дүн шинжилгээ хийх. Цуглуулсан мэдээллүүдийн хоорондын холбоо, хамаарлыг шинжлэх.
- **Судалгааны үр дүнг тайлбарлах:** Шинжилсэн өгөгдөл, боловсруулсан мэдээллийг судалгааны асуудлын хүрээнд тайлбарлаж, цуглуулсан нотлох баримтаас дүгнэлт, саналыг гаргах.

- **Үр дүнг тайлагнах:** Үр дүнг тайлагнахдаа судалгаанд ашигласан эх сурвалжуудыг системчлэн, гаргасан дүгнэлттэй хэрхэн уялдаж буй талаар танилцуулах.

Судалгаанд баримт бичгийн судалгааны арга зүйг ашиглах нь олон давуу талыг бий болгодог. Тухайлбал, судалгаатай холбоотой өмнө нь тодорхойлогдсон загвар, мэдээллийг цаг хугацааны дарааллаар цуглуулах нарийн арга, зохих статистик дүн шинжилгээ зэргийг багтааж болдог ба үр дүнгийн найдвартай байдал, практик ач холбогдлыг нэмэгдүүлдэг. Мөн уг арга зүй нь судалгааг дахин давтах, цаашид дэлгэрүүлэн судлах боломжийг олгодог бөгөөд энэ шинж чанар нь тухайн салбарын хөгжилд ач холбогдол ихтэй байдаг. Харин сул тал нь цаг хугацаа их шаарддаг, нэг талыг барьсан түүвэрлэлт мэдээллийг цуглуулах боломжтой, мэдээлэл цуглуулах хэрэгсэл хангалтгүй, арга зүйн хязгаарлалт зэргээс үүдэн үр дүнг хэт ерөнхий тайлбарлаж болзошгүй байдаг. Судалгааны ерөнхий чанар, найдвартай байдлыг үнэлэхдээ тус судалгааны арга зүйн сул талыг харгалзан үзэхийг анхаарах хэрэгтэй.

### 3.3 Харьцуулсан шинжилгээ

Харьцуулсан шинжилгээний арга зүй нь харилцан адилгүй нөхцөл байдал, зохион байгуулалтын янз бүрийн бүтэц, засаглалын механизм, шийдвэр гаргах үйл явц зэрэгт системчилсэн дүн шинжилгээ хийх, харьцуулахад ашиглагддаг судалгааны арга юм. Энэ аргыг нийгмийн шинжлэх ухаан, улс төрийн шинжлэх ухаан, эдийн засаг, бизнес, антропологи гэх мэт салбарт өргөн ашигладаг.

ЖДҮ-ийн санхүүжилт, зээлийн батлан даалтын тогтолцооны харьцуулсан шинжилгээг санхүүжилтийн ялгаатай загваруудын үр нөлөөг үнэлэх, зээлийн баталгааны янз бүрийн механизмуудын гүйцэтгэлийг үнэлэх, жижиг, дунд бизнесийг дэмжих бүтцийн оновчтой болгох, бодлого боловсруулагчид болон санхүүгийн байгууллагуудад туслах шилдэг туршлагыг тодорхойлоход байдлаар ашиглаж болно. Энэ нь ЖДҮ-ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд үндэслэлтэй шийдвэр гаргахад ач холбогдол өндөр байна.

Харьцуулсан судалгааг хийхэд дараах алхмуудыг баримтална.

**Судалгааны зорилгыг тодорхойлох:** Харьцуулсан дүн шинжилгээ хийх замаар шийдвэрлэхийг хүсэж буй судалгааны зорилго, асуултуудаа тодорхойлох. Харьцуулахыг хүсэж буй тодорхой талууд болон судалгааны зорилгыг тодорхойл.

**Харьцуулах тохиолдол эсвэл аж ахуйн нэгжийг сонгох:** Судлах хэргүүд эсвэл байгууллага, объектоо нарийвчлан сонгох. Эдгээр нь улс орон, компаниуд, хувь хүмүүс, бүс нутаг эсвэл бусад холбогдох шинжилгээний нэгжүүд байж болно. Сонгосон объект судалгааны зорилгод нийцэж байх ёстой.

**Судлагдсан байдлын тойм:** Өөрийн сэдэвтэй холбоотой одоо байгаа судалгаа, онолыг ойлгохын тулд судлагдсан байдлын тоймыг хийнэ. Энэ нь харьцуулсан дүн шинжилгээг удирдан чиглүүлэх гол хувьсагч, ойлголт, хүрээг тодорхойлоход тусална.

**Онолын хүрээг боловсруулах:** Харьцуулсан шинжилгээний үзэл баримтлалын үндэс болох онолыг судална. Энэхүү хүрээ нь шинжилгээний явцад судлах гол хувьсагч, хамаарал, таамаглалыг тодруулах юм.

**Харьцуулсан аргуудыг сонгох:** Харьцуулсан дүн шинжилгээ хийхдээ тохирох аргыг сонгох. Үүнд:

**Чанарын харьцуулсан шинжилгээ:** Чанарын өгөгдлийг ашиглан тохиолдлуудын хэв маягийг судлах.

**Тоон харьцуулсан шинжилгээ:** Загвар, хамаарлыг тодорхойлохын тулд тоон өгөгдөлд дүн шинжилгээ хийх.

**Кейсийн судалгааны дүн шинжилгээ:** Ойлголт гаргахын тулд хоорондоо хамааралгүй, ялгаатай тохиолдлуудыг гүнзгийрүүлэн судлах.

**Үндэстэн дамнасан харьцуулсан шинжилгээ:** Өөр өөр улс орнуудын өгөгдлийг харьцуулах.

**Мэдээлэл цуглуулах:** Тохиолдол бүрт холбогдох өгөгдлийг цуглуулж, мэдээлэл цуглуулах аргын тууштай байдлыг хангах. Үүнд судалгааны загвараас хамааран чанарын болон тоон мэдээллийг цуглуулж болно.

**Мэдээллийн дүн шинжилгээ хийх:** Сонгосон аналитик аргуудыг өөрийн өгөгдөлд хэрэглэх. Үүнд статистик дүн шинжилгээ, агуулгын дүн шинжилгээ эсвэл бусад холбогдох арга техникүүд багтаж болно. Өгөгдөл дэх хэв маяг, чиг хандлага, харилцаа холбоог тодорхойлж, тайлбарлах.

**Харьцуулах ба ялгах:** Тохиолдлуудын үр дүнг системтэйгээр харьцуулж ялгах. Ижил төстэй байдал, ялгаа болон гарч ирсэн хэв маягийг тодруулах. Улмаар судалгааны зорилго, онолын хүрээтэй хэрхэн холбогдож байгааг авч үзэх.


**Дүгнэлт гаргах:** Шинжилгээний үр дүнг нэгтгэн дүгнэлт гаргах.

## IV БҮЛЭГ. ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ

### 4.1 Жижиг, дунд үйлдвэрийн эдийн засаг дахь нөлөөний харьцуулсан шинжилгээ

Олон улсын хэмжээнд ЖДҮ-ийн хөгжлийн түвшнийг тодорхойлохдоо ДНБ, ажлын байранд оруулж буй хувь болон ЖДҮ-ийн борлуулалтын орлого, экспортод эзлэх хувийг харгалзаж үздэг. Эдгээр хүчин зүйлийн нэг болох ажилчдыг ЖДҮ салбарын ангиллаар ялган харахад монгол улсын нийт ЖДҮ эрхлэгч ААН-ийн 92 хувийг 10 хүртэлх ажилтантай буюу бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид эзэлж байгаа бол тэдний 82 хувь нь 300 сая хүртэлх борлуулалтын орлоготой байна. Цаашилбал, манай улсад 2017 оны байдлаар бүртгэлтэй 158175 аж ахуйн нэгжийн 75749 нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагаагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн 48079 буюу 56 хувь нь жижиг, дунд үйлдвэрийн салбарт харьяалагдаж, нийт ажиллах хүчний 67 хувь буюу 963,146 нь ЖДҮ салбарт ажиллаж байна (Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, 2020). Харин эдгээр тоо нь 2022 онд 69539 аж ахуй нэгж, 992819 ажилчид, ажиллах хүчинд эзлэх хувь 78.5% болж өсжээ.

Зураг 4.1 Монгол улсын жижиг, дунд үйлдвэрийн ажил эрхлэлт




Эх сурвалж: [УСХ](#), ААНТ-2021, (Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, 2020)

Манай улсын эдийн засаг уул уурхайгаас хэт их хамааралтайг харгалзаж үзвэл ЖДҮ-ийн эдийн засагт гүйцэтгэж буй үүрэг их байна. Тухайлбал нийт ажиллах хүчний дөрөвний гурав нь ЖДҮ-ийн салбарт ажиллаж байгаа бөгөөд дотоодын нийт бүтээгдэхүүний 6 орчим хувийг бүрдүүлж байна. Харин ЖДҮ эрхэлж буй аж ахуйн нэгжийн 2 хувь нь экспортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж, үлдсэн 98 хувь нь дотоодтоо үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс манай улс уул уурхайн бүтээгдэхүүнийг эс тооцвол экспортлогч бус улс болох нь харагдаж байна. Мөн хэрэглээний хувьд импортын бараа үйлчилгээг түлхүү хэрэглэж, ашиглаж байгаагаас ЖДҮ салбарын үйлдвэрлэл, гарцыг нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих нөгөө талаас экспортод чиглэсэн ЖДҮ-г бодлогоор дэмжих хэрэгцээ, шаардлага байна. Харин ЖДҮ салбарын ажил эрхлэлт болон эдийн засаг дахь хувь нэмрийг харьцуулан харвал ЖДҮ салбарын ажиллах хүчийг дутуу ашиглаж байгаа нь харагдаж байна.

Манай улсад нийт үйл ажиллагаагаа идэвхитэй явуулж буй аж ахуйн нэгжийн 76 хувийг ЖДҮ-ийн салбарын аж ахуйн нэгж эзэлж байна. Эдгээр аж ахуй нэгжийн 60 орчим хувийг худалдаа, үйлчилгээ, 10 хувийг барилга, 8 хувийг аж үйлдвэр, 5 хувийг хөдөө аж ахуй, 17 орчим хувийг бусад салбаруудад үйл ажиллагаа эрхэлж буй ААН-үүд бүрдүүлж байна.

Зураг 4.2 Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж



Эх сурвалж: [Үндэсний статистикийн хороо](#)

Үргэлжлүүлэн олон улсад эдгээр үзүүлэлт ямар байгаа талаар шинжилье.

Зураг 4.3 Мянган хүн тутамд ногдох ЖДҮ-ийн тоо, 2001-2006




Эх сурвалж: *Тогтвортой хөгжлийн Дэлхийн бизнесийн зөвлөл, 2007*

Зураг 4.3-т Ази, Номхон далайн бүс нутгийн болон бусад хөгжингүй орнуудад ЖДҮ-ийн тархалт өндөр байгааг харуулж байна. Ази, Номхон далайн бүс нутагт 2001-2006 онд 1000 хүн тутамд 63 ЖДҮ ногдож байна. Үүний эсрэгээр тухайн бүс нутгийн хөгжиж буй орнуудад харьцангуй бага буюу 1000 хүн тутамд 27 ЖДҮ бүртгэгдсэн байхад буурай хөгжилтэй орнуудад 1000 хүнд ердөө 9 ЖДҮ ногдож байна. Манай орны хувьд 2022 оны байдлаар 1000 хүнд ердөө 20.1 ЖДҮ эрхлэгч аж ахуй нэгж ногдож байна. Үүнээс Ази, Номхон далайн бүс нутгийн нутагтаа болон олон улстай харьцуулахад ЖДҮ эрхлэгч аж



ахуйн нэгжийн тоогоо нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна. ЖДҮ-ийн өсөлтийг хэмжих дараагийн үзүүлэлт болох ДНБ-д эзэлж буй тус салбарын нөлөөг бусад улстай харьцуулан авч үзлээ.


Зураг 4.4 ЖДҮ-ийн ДНБ-д эзлэх хувь, орлогын ялгаатай улсуудаар



Эх сурвалж: (Asian Development Bank)

Жижиг, дунд үйлдвэрийн эдийн засагт үзүүлж буй нөлөө улсуудын орлогын ялгаатай түвшнээс хамааран харилцан адилгүй байна. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн өндөртэй улс орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүний 45%, ажил эрхлэлтийн 45% -ийг жижиг, дунд үйлдвэр бий болгож байгаа бол бага орлоготой орнуудын ажил эрхлэлтийн 51%, ДНБ-д 21%-ийг эзэлж байна. Үүнд нэг хүнд ногдох орлого өндөр болохын хэрээр буюу улс орнууд хөгжих тусам ЖДҮ-ийн ажил эрхлэлт буурах хандлага ажиглагдаж байгаа бөгөөд эдийн засагт үзүүлэх нөлөө нэмэгдэж байна. Өөрөөр ЖДҮ-ийн салбарын хөдөлмөрийн бүтээмж орлогын түвшин нэмэгдэхийн хэрээр өсч байна. Харин дундаж орлоготой улсуудын ЖДҮ нь ажил эрхлэлтийн 40 гаруй хувийг бүрдүүлж, эдийн засагт оруулж буй нөлөө харилцан адилгүй байна.

Зураг 4.5 Жижиг, дунд үйлдвэрийн ажил эрхлэлт, орлогын ялгаатай улсуудаар



Эх сурвалж: (Asian Development Bank, 2022)

Бага орлоготой орнуудад ЖДҮ-ийн салбар нь нийт ажиллагсдын дийлэнх хувийг эзэлдэг мөн орлогын гол эх үүсвэр болдог ба ядуурлыг бууруулах замаар эдийн засгийн өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэж байна. Дундаж орлоготой орнуудад ЖДҮ эрхлэгчид ажлын байр, орлогын томоохон эх үүсвэрүүдийг бий болгож буй хэвээр байгаа ч томоохон компаниуд болон гадаадын пүүсүүдийн өрсөлдөөнтэй тулгарч магадгүй байна. Харин өндөр орлоготой орнуудад томоохон компаниуд зах зээлд ноёрхож хандлагатай байгаа бөгөөд ЖДҮ-ийн нэр хүнд тэдгээр компаниудтай харьцуулахад бага байна. Гэхдээ өндөр орлоготой орнуудын ЖДҮ нь төрөлжсөн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангаж, орон нутгийн эдийн засаг, инновацийг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн хэвээр байна.

## 4.2 Жижиг, дунд үйлдвэрийн санхүүжилтэд тулгарч буй гол саад бэрхшээл

### 4.2.1 Олон улсын ЖДҮ-ийн санхүүжилтэд тулгарч буй бэрхшээл, шийдвэрлэх арга зам, туршлага

Олон улсад ЖДҮ-ийн банкны зээлийн хүртээмжийн хязгаарлагдмал байдал нь ЖДҮ-ийн бүтцийн асуудал болж байна. ЖДҮ-д олгосон банкнуудын зээл ДНБ-ий 11.6%, нийт банкны зээлийн 18.7%-ийг эзэлж байгаа бөгөөд 2008 оны дэлхийн санхүүгийн хямралаас хойш буурах хандлагатай байна. ЖДҮ-ийн банкны зээлийн хүртээмжийг үйл ажиллагаа явуулж буй орнуудын орлогын түвшинтэй нь харьцуулж үзвэл, тус улсын эдийн засаг илүү хөгжихийн хэрээр банкны зээл илүү олон тооны ЖДҮ-д (чанаргүй зээлийн харьцаа харьцангуй бага) хүрч байна (Asian Development Bank, 2015). ЖДҮ-үүд санхүүжилт авахад хүндрэлтэй байдал нь тухайн орны эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтэд хүчтэй сөрөг нөлөө үзүүлэх аюултай бөгөөд ялангуяа хөгжиж буй орнууд цаашид бодлогоор дэмжих шаардлагатай байна.

Энэтхэгийн 70%, Хятадын 80%, Малайзын санхүүгийн системийн 90% нь банкны зээлээс бүрддэг (Kuwahara, 2016). Судлаачид Азийн эдийн засгийг банкнууд давамгайлсан санхүүгийн зах зээлтэй, хөрөнгийн зах зээл, ялангуяа венчур капитал хөгжөөгүй гэж тодорхойлжээ. Өөрөөр санхүүжилтийн гол эх үүсвэр нь банкнууд гэсэн үг. Дэлхийн санхүүгийн хямралаас хойш банкны системийн тогтвортой байдал сайжирсан ба эдийн засгийн үйл ажиллагааны дийлэнх хувийг банкны зээлтэй аж ахуйн нэгж бүрдүүлж байгаа боловч банкнууд ЖДҮ-д зээл олгохдоо болгоомжтой хандсан хэвээр байна.


Ялангуяа гарааны бизнес эрхлэгч банкнаас мөнгө зээлэхэд улам хүндрэлтэй болж байна. Нөгөө талаас банкнууд ерөнхийдөө ЖДҮ-ийг үнэлэхэд хүндрэлтэй, улам төвөгтэй болж байгаа нь үүнд нөлөөлж байна. Үр дүнд ихэнх оронд ЖДҮ-үүд өндөр хүү төлж эсвэл өндөр үнэлгээтэй барьцаа санал болгосны дараа тодорхой хэмжээний мөнгө зээлж байна. Мөн дийлэнх банк ЖДҮ гэхээсээ илүү томоохон аж ахуйн нэгжүүдэд зээл олгохыг илүүд үздэг. Үүний шалтгаан нь томоохон аж ахуйн нэгжүүд нь ЖДҮ-тэй харьцуулахад санхүүгийн тайлангууд нь илүү тодорхой, аудитлагдсан байдаг. Цаашлан ЖДҮ-ийн бизнесийн орчны олон улсад судлагдсан байдал хэсгийн (Shinozaki, 2012), (Cheng, 2019) болон (Asian Development Bank, 2023) судалгааг нэгтгэн харахад ЖДҮ эрхлэгчид банкны зээл авахад барьцаа болон баталгааны шаардлага, зээлийн хүү өндөр байгаа нь хамгийн их хүндрэлийг бий болгож байна. Тодруулбал, барьцаа хөрөнгө, баталгааны хэт өндөр шаардлага, ЖДҮ-ийн зээлдэгчдэд хэт өндөр зээлийн хүү ногдуулдаг нь ЖДҮ-ийн зээлийн нийлүүлэлтийг бууруулж, өсөлтөд сөргөөр нөлөөлж байна.

Улс орнууд ЖДҮ-ийн санхүүжилтийн асуудлаа төрөл бүрийн арга хэрэгслийг ашиглаж байна. Үүнд хөгжингүй орнууд ЖДҮ-г дэмжихээр илүү уян хатан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлж, төрийн зохицуулалт буюу бизнесийн орчныг сайжруулахад ач холбогдол өгсөөр иржээ. Ихэнх орнууд ЖДҮ-ийг дэмждэг хөтөлбөрүүдтэй байдаг. OECD орнуудын нийт төрийн дэмжлэгтэй хөтөлбөрийн дөрөвний нэг нь ЖДҮ-д чиглүүлж байна. Герман, Исланд, Япон, Шинэ Зеланд улс төрийн дэмжлэг үзүүлэх нийт хөтөлбөрийн 50 гаруй хувийг ЖДҮ-д зориулжээ. Тодруулбал гарааны бизнест туслах, тоног төхөөрөмж худалдан авах, судалгаа шинжилгээ хийх, сургалт, зөвлөгөө өгөх зэрэгт шууд буцалтгүй тусламж, татварын хөнгөлөлт үзүүлэх, бага хүүтэй зээл эсвэл зээлийн баталгаа үзүүлэх зэргээр дэмжиж байна. Харин Азийн хөгжлийн банк ЖДҮ-ийн санхүүжилтийг хөнгөвчлөх гурван төрлийн аргыг улс орнуудад зөвлөсөн ба зарим оронд эдгээр аргууд нь амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд бусад орнуудад өргөжүүлэх шаардлагатай байгааг онцолж байна. Үүнд:

Судалгаанд ЖДҮ эрхлэгчдэд тулгарч буй санхүүгийн бэрхшээлийг тодорхойлж, тэдгээрийг бууруулах боломжийг санал болгожээ. Дээрх санал болгосон аргуудаас зээлийн батлан даалтын тогтолцоог боловсруулах аргыг нарийвчлан авч үзье. Олон улс орнууд зээлийн батлан даалтыг олон арван жилийн турш янз бүрийн хэлбэрээр, зорилтот салбар, бүлэгт чиглэсэн хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэх арга болгон ашиглаж иржээ. Ийм схемийг бий болгох зорилго нь хөрөнгө босгоход хүндрэлтэй байгаа салбарууд, тэр дундаа ЖДҮ-ийн салбар руу чиглэсэн санхүүжилтийн урсгалын нэмэгдүүлэхэд оршдог. (Zander, Miller, and Mhlanga 2013). Мөн олон улсад зээлийн батлан даалтын эдийн засаг, ЖДҮ дэх нөлөөг чухалчилж байна.

#### 4.2.2 Монгол улсын ЖДҮ-ийн санхүүжилтэд тулгарч буй бэрхшээл, санхүүжилтийн эх үүсвэр

Зураг 4.6 Жижиг, дунд үйлдвэрийн өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлс



Эх сурвалж: Монголбанк, 2022

Бизнесийн үйл ажиллагаа, санхүүжилтийн байдлын 2021 оны судалгаагаар бизнесийн орчны ерөнхий индекс -0.28 буюу бизнесийн орчин "муу" үнэлгээтэй байна. Гэхдээ 2020 оны бизнесийн орчны ерөнхий индекстэй харьцуулахад сайжирсан хэдий ч үнэлгээ нь "муу" түвшинд хэвээр байна (Монгол банк, 2022). Бизнесийн орчны муу байдал ЖДҮ-д хэрхэн нөлөөлж буй талаар нөлөөлөгч хүчин зүйлсээр дор задлан авч үзлээ.

**Макро эдийн засгийн орчин:** Инфляц болон валютын ханшийн тогтворгүй байдал нь ЖДҮ-ийн өсөлтөд хамгийн их бэрхшээл учруулдаг бөгөөд уг судалгаанд хамрагдаж буй ЖДҮ-ийн бизнес эрхлэгчид бизнес эрхлэхэд эдийн засгийн нөхцөл хангалттай таатай биш гэж үзжээ.

**Нийгэм, улс төрийн байдал:** Үүнд хамгийн хэцүү асуудал бол ажилгүйдэл, ядуурал, хээл хахууль байна. Энэ нөлөө нь барилгын салбар, дотоод худалдааны аж ахуйн нэгжүүдэд илүү байна. Нийт хүн амын ядуурлын түвшин нь хэрэглэгчдийн худалдан авах чадварт сөргөөр нөлөөлж, улмаар жижиг, дунд үйлдвэрүүдийн (ЖДҮ) борлуулалтын орлогыг бууруулжээ. Энэ нь эргээд эргэлтийн хөрөнгийн хомсдолд хүргэж, цаашлаад зээлийн эргэн төлөлтийн үүргээ биелүүлэхэд хүндрэл учруулж байна. Түүнчлэн төрийн байгууллага зарим үйлчилгээгээ шударга бусаар гүйцэтгэж, хүнд

сурталтай байгаа нь ЖДҮ-ийн бизнес эрхлэгчдэд ихээхэн бэрхшээл, хүндрэл учруулж байна.

**Хууль, эрх зүй, төрийн зохицуулалт:** ЖДҮ-ийн бизнес эрхлэгчид хууль эрх зүйн орчны хүрээнд гадаад худалдаа хийх нөхцөл, газар эзэмших боломж, татварын тогтолцоо хамгийн их бэрхшээлийг үүсгэж байна. Дэлхийн банкны судалгаагаар дунд орлоготой орнуудын жижиг, дунд үйлдвэрүүдэд (ЖДҮ) тулгардаг асуудлын 40 орчим хувь нь хууль эрх зүйн болон зохицуулалтын орчны бэрхшээлээс үүдэлтэй гэж дүгнэжээ. Мөн ЖДҮ-ийг дэмжсэн цогц хууль эрх зүйн орчныг бий болгосноор ЖДҮ бизнесүүдийн өсөлт болон улс орны нийт эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулан гэж үзжээ. Иймээс ЖДҮ-ийг хөгжүүлэх таатай эрх зүйн орчныг бүрдүүлэх нь анхаарах шаардлагатай асуудал. Монгол Улс 2007 онд "Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай" хуулийг баталж, 2017 онд ЖДҮ-ийн тухай хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулан бизнес эрхлэгчидтэй өргөн хүрээнд хэлэлцүүлжээ. Улмаар шинэчилсэн найруулгын төслийг 2019 онд УИХ-аар батлуулсан. Үүнд зээлийн давхар батлан даалтыг хориглосон нь ЖДҮ-ийн өсөлтөд сөрөг нөлөөтэй. Үүнийг хуулийн хүрээнд сэргээхэд давхар батлан даалттай зээлийг зориулалтын дагуу зарцуулах шаардлагатай.

**Зах зээлийн орчин:** Иргэдийн худалдан авах чадвар зах зээлийн орчны үзүүлэлтүүдээс хамгийн муу үзүүлэлт болжээ. Зах зээл нь хэрэглэгчдийн худалдан авалт, зах зээлийн өрсөлдөөн, зах зээлд эзлэх хувь, шударга өрсөлдөөн зэрэг хамруулдаг ба ЖДҮ бизнес эрхлэгчдэд маш их нөлөөлдөг. Иргэдийн худалдан авах чадвар муу байгаа нь ЖДҮ эрхлэгчдийн борлуулалтын орлогыг бууруулах нөлөөтэй ба эдийн засгийн эргэлтийг удаашруулах сөрөг нөлөөтэй.

**Дэд бүтцийн хөгжил:** Уг судалгаагаар дэд бүтцийн хөгжлийн хувьд харьцангуй боломжийн буюу бизнесийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө багатай байна гэсэн үр дүн гарчээ. Бүлгийн индексийн эерэг үр дүнд мэдээлэл харилцаа холбоо, цахилгаан түгээлт, усан хангамжтай холбоотой үзүүлэлтүүдээс гол нөлөөг үзүүлжээ. Уг судалгаа нь аймаг, нийслэлийн ЖДҮ-ийн хөгжилд дэд бүтцийн нөлөөллийг харьцуулан дүгнэжээ. Үр дүнд Хөвсгөл, Дархан-Уул, Баянхонгор, Хэнтий Завхан, Орхон зэрэг аймгуудад дэд бүтцийн асуудал хүндрэлтэй гэжээ. Харин Архангай аймгийн ЖДҮ эрхлэгчид дэд бүтцийн орчин сайн, бусад аймгууд хангалттай гэж үзэж байна. Харин ЖДҮ бизнес эрхлэгчид дэд бүтцийн хөгжлийн зүгээс хамгийн их хүндрэл учруулдаг үзүүлэлт нь тээвэрлэлт болон зам гэсэн үзүүлэлтүүд гэж үнэлжээ.

**Санхүүжилтийн орчин:** ЖДҮ-ийн санхүүжилтийн орчны үнэлгээгээр барьцаа хөрөнгийн дутагдал, үнэлгээ, зээлийн өндөр хүү, зээлийн шимтгэл зэрэг хүчин зүйлс нь ЖДҮ-ийн өсөлтийг хамгийн их хязгаарлаж буй үр дүн гарчээ. Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 76 хувь нь банкны зээл, 12 хувь нь хөнгөлөлттэй зээлийг санхүүжилтийн эх үүсвэрээ болгосон байна. Арилжааны банкнаас зээл авсан ЖДҮ эрхлэгчдийн 13 хувь нь зээлээ хугацаанд нь төлөхөд бэрхшээлтэй тулгарсан. ЖДҮ-ийг дэмжихийн тулд барьцаа хөрөнгийн дутмаг асуудлыг шийдвэрлэх санхүүгийн механизм, урт хугацаатай, бага хүүтэй хөнгөлөлттэй зээл олгох арга замыг судалж, зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх санхүүгийн хэрэгслийг нэвтрүүлэх шаардлагатай байна (Монгол банк, 2018).

**Дотоод үйл ажиллагаа:** Мэргэшсэн ажиллах хүчний нийлүүлэлт бага, тогтворгүй ажиллаж байгаа нь ЖДҮ бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлж байна. Ур чадвартай ажиллах хүчин нь бүтээмжийг нэмэгдүүлэх, гарцыг өсгөх үр нөлөөтэй.

Нэгтгэн дүгнэвэл өндөр инфляц, ажилгүйдэл, хээл хахууль, гадаад худалдаа хийх таагүй нөхцөл, газар эзэмших боломж муу, татварын буруу тогтолцоо, иргэдийн худалдан авах чадвар муу, зам, тээвэрлэлтийн нөхцөл муу, зээлийн барьцаа хөрөнгийн дутмаг байдал, буруу үнэлгээ, зээлийн хүү, шимтгэл өндөр, ур чадвартай хүний нөөцийн дутагдалтай байдал нь ЖДҮ-ийн өсөлтийг хамгийн их хязгаарлаж байна. Үүнээс ДНБ-ний өсөлтийг нэмэгдүүлэх, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор ЖДҮ-ийн санхүүжилтийн таатай орчныг бүрдүүлэх нь чухал байна. Үргэлжлүүлэн Монгол улсын ЖДҮ-ийн санхүүжилтийн байдлын өнөөгийн нөхцөл байдлыг шинжилье.

Бизнесийн үйл ажиллагаа, санхүүжилтийн байдал (Монгол банк, 2022) судалгаанд хамрагдсан ЖДҮ-д дотоодын арилжааны банк бусад санхүүгийн байгууллага болон ААН дотоодын эх үүсвэр, нөөц бололцоогоороо (харгалзан 35% болон 63%) санхүүжилтээ шийдэж байна.


Зураг 4.7 Санхүүжилтийн эх үүсвэр, ЖДҮ-ийн хэмжээгээр



Эх сурвалж: (Монгол банк, 2022)

Харин 2017-2018 онд санхүүжилт авсан ЖДҮ-ийн 76% буюу дөрөвний гурав нь арилжааны банкны зээл, 12% нь хөнгөлөлттэй зээл авч санхүүжилтийн асуудлаа шийдвэрлэжээ.

Зураг 4.8 Санхүүжилтийн эх үүсвэр



Эх сурвалж: (Монгол банк, 2018)

ЖДҮ эрхлэгчид арилжааны банкны зээлээр санхүүжилтээ түлхүү шийдэж байгаагаас арилжааны банкны ЖДҮ-д олгох зээлийг хөнгөвчлөх, зээлийн эрсдэлийг бууруулах шийдлүүдийг эрэлхийлэх нь ЖДҮ-ийн өсөлтийг нэмэгдүүлэхэд бодит үр дүнтэй хувилбаруудын нэг болж байна. Тиймээс засгийн газар, донор байгууллагууд ЖДҮ-ийн санхүүжилтийн асуудлыг банкаар дамжуулан шийдвэрлэхэд өндөр ач холбогдол өгөх хэрэгтэй юм. Үүнд донор байгууллагын хувьд арилжааны банкаар дамжуулан ЖДҮ-г дэмжих хөтөлбөрүүдийг явуулж байгаа бол засгийн газар ЖДҮ-ийн санхүүгийн бэрхшээлийг арилжааны банкны зээлээр шийдэхэд хөндлөнгөөс оролцох буюу олон улсын жишгийн дагуу зээлийн тодорхой хувьд батлан даалт гаргах боломжтой байдаг.

Харин зээл авч чадаагүй ЖДҮ-ийн зээл авах нөхцөлөө хангаагүй шалтгаан нь барьцаа хөрөнгийн дутмаг байдлаас хамгийн их хамааралтай байна.

Зураг 4.9 Зээл авах нөхцөлөө хангаагүй шалтгаан



Эх сурвалж: ЖДҮ-ийн түүвэр судалгаа -2018

ЖДҮ-ийн барьцаа хөрөнгө хангалтгүйгээс үүдэн тэдэнд олгох зээлийн хүү өндөр байгаа нь ЖДҮ-ийн зээлийг өргөжүүлэхэд томоохон саад болж байна. Мөн зээлийн мэдээллийн сан сөрөг гэсэн үзүүлэлт 10% байгаа нь зээлдэгч томоохон аж ахуйн нэгж, компанид барьцаа хөрөнгө хангалттай, зээлийн мэдээллийн түүх сайн, илүү найдвартай гэж үзэн зээл олгох хандлагатай байгааг харуулж байна.

#### 4.3 Зээлийн батлан даалтын сангийн өнөөгийн нөхцөл байдал

ЖДҮ эрхлэгч аж ахуйн нэгжид санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, барьцаа хөрөнгийн асуудлыг шийдэхэд зориулагдсан төрийн оролцоот санхүүгийн механизм нь зээлийн батлан даалтын тогтолцоо юм. Ихэнх орнуудад уг санхүүгийн механизмыг ашиглан ЖДҮ-ийн барьцаа хөрөнгийн дутмаг байдлаас үүдэлтэй санхүүгийн асуудлыг шийдвэрлэсээр ирсэн ба хөгжингүй орнуудад улам төгөлдөржин, сайжирсаар байна. Олон улсад засгийн газар нь шууд баталгаа гаргах загвар түгээмэл байгаа бол зарим улсуудад засгийн газраас зөвшөөрөл авсан хөндлөнгийн байгууллага баталгаа гаргаж байна. Зээлийн батлан даалтын системийг ихэвчлэн ЖДҮ-ийн санхүүжилтээр мэргэшсэн төрийн байгууллага, агентууд удирддаг бол манай улсын хувьд засгийн газраас 2012 онд үүсгэн байгуулсан “Зээлийн батлан даалтын сан” санхүүгийн байгууллага удирдаж баталгаа гаргаж байна. Тодруулбал, УИХ-аас 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдөр


Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийг баталж, 2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр зээлийн батлан даалтын сан (ЗБДС) байгуулагдсан. Уг сан нь барьцаа хөрөнгийн дутагдалтай ЖДҮ эрхлэгчдэд батлан даалт гаргах ашгийн төлөө бус байгууллага ба үндсэн үйл ажиллагааны чиглэл нь шууд бус батлан даалт байна. Манай улсын хувьд зээлдэгчид олгох зээлийн батлан даалтын дээд хэмжээ нь 500 хүртэлх сая төгрөг ба нийт зээлийн 60 хүртэлх хувьд салбар харгалзахгүй баталгаа гаргаж байна. ЗБДС үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш 10 жил өнгөрсөн бөгөөд өнгөрсөн хугацаанд нийт 1121 зээлдэгчдийн 325.7 тэрбум төгрөг зээлийн 49% буюу 159.9 тэрбум төгрөгийн зээлийг батлан даажээ. Харин зээлийн батлан даалт гаргаснаар шинээр 5034 ажлын байр бий болсон бол 12112 ажлын байрыг хадгалж чаджээ. Энэ нь нийт ажиллах хүчний 1.5 хувь, ЖДҮ-ийн салбарын ажил эрхлэлтийн 1.2 хувь буюу ЖДҮ салбарт үзүүлж буй нөлөө хангалтгүй байна.

#### Хүснэгт 4.1 Зээлийн батлан даалтын сангийн эдийн засагт оруулж буй нөлөө

	Батлан даалтад хамрагдсан ААН-ийн тоо	Батлан даалттай зээлийн дүн (сая.төг)	Батлан даалтын дүн (сая.төг)	Зээлд эзлэх батлан даалтын хувь хэмжээ	Хадгалсан ажлын байр	Шинээр нэмэгдсэн ажлын байр
<b>2013</b>	52	9,602.10	3,371.54	35%	434	202
<b>2014</b>	252	37,803.11	16,459.07	44%	1932	820
<b>2015</b>	96	23,740.79	9,395.20	40%	927	320
<b>2016</b>	39	20,260.30	8,495.08	42%	723	190
<b>2017</b>	49	17,509.00	8,285.37	47%	605	365
<b>2018</b>	174	59,512.97	33,210.82	56%	2151	1204
<b>2019</b>	111	37,763.81	20,539.75	54%	902	510
<b>2020</b>	66	24,865.88	12,643.41	51%	468	313
<b>2021</b>	242	68,317.30	33,757.67	49%	1973	635
<b>2022</b>	40	26,300.00	13,731.77	52%	457	194
<b>Нийт</b>	<b>1121</b>	<b>325,675.26</b>	<b>159,889.67</b>	<b>49%</b>	<b>10572</b>	<b>4753</b>

Эх сурвалж: [www.cgf.mn](http://www.cgf.mn)


Зураг 4.10 ЗБДС-ийн эдийн засгийн үзүүлэлт I



Эх сурвалж: [www.cgf.mn](http://www.cgf.mn)



Зураг 4.11 ЗБДС-ийн эдийн засгийн үзүүлэлт 2



Эх сурвалж: [www.cgf.mn](http://www.cgf.mn)

Батлан даагдсан зээлдэгчдийн тоог салбараар авч үзэхэд худалдаа, үйлчилгээний салбар 52%, үйлдвэрлэл 35%-г эзэлж байгаа бол хөдөө аж ахуй 9%, барилга 4%, боловсролын салбар 1% эзэлж байна. Байршлын хувьд 70 хувь нь нийслэл, 30 орчим хувь нь орон нутагт байна.

Зураг 4.12 Зээлийн батлан даалт гаргах үе шат



Эх сурвалж: [www.cgf.mn](http://www.cgf.mn)

Зээлийн баталгаа нь ЖДҮ эрхлэгч арилжааны банканд батлан даалтын хүсэлт илгээснээр эхлэх бөгөөд ЗБДС нь батлан даалтын судалгаа хийсний үндсэн дээр арилжааны банканд баталгаа өгч улмаар арилжааны банкнаас ЖДҮ-д зээл олгогддог. Олон улсад ЗБДС нь ЖДҮ-д зээлийн баталгаа өгөхийн өмнө зээлийн батлан даах хувь хэмжээг тогтоох шаардлага зүй ёсоор үүсдэг. Манай улсын хувьд зээлийн баталгааг нийт зээлийн 60 хүртэлх хувьд салбар харгалзахгүй баталгаа гаргаж байна.

Харин ЗБДС нь засгийн газар буюу жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд давхар батлан даалтын хүсэлт тавьж, ЖДҮ хөгжүүлэх сан зөвшөөрсөнөөр тухайн зээл давхар батлан даагддаг. Манай орны хувьд давхар батлан даалтын систем нь 2013 оноос 2019 оны хооронд хэрэгжиж байсан хэдий ч 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар хүчингүй болсон. Үүнд дараах заалтууд хүчингүй болсон:

- Сангийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас давхар батлан даахтай холбогдсон журмыг Засгийн газар батална.
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас Сангийн гаргасан нийт батлан даалтын 60 хүртэл хувийг давхар батлан даана.

Давхар батлан даалтыг хүчингүй болгоход ЖДҮ-ийн зээлийн үр ашиггүй байдлыг нэмэгдүүлсэн, нөгөө талаас өөрийн хөрөнгө шавхагдах эрсдэлтэй гэсэн нь гол үндэслэл болсныг ярилцлагын аргаар тодрууллаа.

#### **4.4 Зээлийн батлан даалтын харьцааны харьцуулсан шинжилгээ**

Зээлийн батлан даалтын харьцааг улс орон бүр харилцан адилгүй тогтоожээ. Хөгжиж буй орнуудын хувьд хөгжингүй орны туршлагыг судлан уг харьцааг импортоор авах хандлага түгээмэл байна. Нөгөө талаас бодлого боловсруулагчид нухацтай байж, уг харьцааг хэт өндөр тогтоож болохгүй. Зээлдэгчдийг зохих ёсоор шалгаж, зээлийн үнэлгээ хийлгэх, эрсдэлийн түвшнийг зөв үнэлж зээлийн батлан даалтын харьцааг оновчтой тогтоох хэрэгтэй. Цөөн хэдэн улс орон давхар батлан даалтын системтэй байгаа бөгөөд зээлийн баталгааны харьцааг тодорхой бүлэгт чиглэсэн жижиг бизнес эрхлэгчдийг татах бодлогын хэрэгсэл болгон ашиглаж байна. Үүнд АНУ, ЕХ-ны улсууд болон азийн хөгжингүй орнууд хамаарч байна. Тухайлбал, БНСУ-д бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд тодорхой ангилж ялгаатай түвшинд баталгаа гаргаж байна. БНСУ нь батлан даалтын гурван сантай бөгөөд эдгээр нь бүх бизнес эрхлэгч, технологид чиглэсэн үйл ажиллагаатай ЖДҮ, бусад жижиг, дунд үйлдвэрүүдэд тодорхой нөхцөлтэйгөөр 50-100% хүртэл батлан дааж байна. Мөн Энэтхэгийн бичил болон жижиг аж ахуйн нэгжүүдэд зориулсан зээлийн батлан даалтын сангийн хөтөлбөрт тус улсын зүүн хойд хэсгийн эмэгтэй бизнес эрхлэгчид болон ЖДҮ эрхлэгчдэд чиглэсэн зэргээс зээлийн баталгаа олон улсад бүх салбар, бизнестээ харилцан адилгүй дэмжиж, зээлийн баталгаа адилгүй түвшинд байгааг харуулж байна.

Дэлхийн 76 зээлийн батлан даалтын байгууллагын зээлийн баталгааны харьцаа дунджаар 80% байна. Харин Европын холбооны улсуудад дээд хязгаар нь 80%-ийн баталгааг төр батлан дааж байна. Кейс харьцуулсан шинжилгээнд сонгосон улс орнуудын хувьд 50%-90% хооронд хэлбэлзэж байна. Цаашилбал хөгжингүй орнууд болон хөгжиж буй хэд хэдэн орнуудын баталгааны харьцаа 100% байна. Гэхдээ зээлдэгчид үүргээ биелүүлээгүй тохиолдолд ямар нэгэн торгууль ногдуулах систем, хариуцлагын тогтолцоо бүх улсад шаардлагатайг онцолж байна. Өөрөөр зээлдэгчийн ёс суртахууны эрсдэл өндөр байна. Канад, Нидерланд, Литва зэрэг улсуудад зээлийн 100 хувийн баталгаа нь стратегийн хувьд дефолтыг бий болгох шалтгаан, дэмжлэг болж байна. Ялангуяа зээлийн баталгааны шинэ схем, загваруудыг ашиглах болон санхүүгийн зах зээл хөгжиж буй

орчинтой үед зээлийн баталгааны харьцааг өндөр түвшинд тогтоох нь дефолтын эрсдэл дагуулж болзошгүй байна.

Харин олон улсад ялангуяа Ази, Номхон далайн бүс нутгийн хөгжиж буй орнууд зээлийн батлан даалтын санг ЖДҮ-г дэмжих бодлогын арга хэрэгсэл болгон өргөнөөр ашиглаж, зээлийн батлан даалтын харьцааг нэмэгдүүлэх хандлагатай байгаа ба зээлийн баталгааны харьцааг нэмэгдүүлсэн нь зээлийн хугацаа болон хүүний түвшинд дам байдлаар нөлөөлөх оновчтой хариу арга хэмжээ болжээ. Үүний дараа хөнгөлөлттэй зээл тусламж, зээлийн хүүний зохицуулалтыг зорилтот салбарууд руу чиглүүлэх дэмжлэг өргөжин тэлж байна.

#### **4.4.1 Зээлийн батлан даалтын харьцааны кейс харьцуулсан шинжилгээ**

##### **Японы зээлийн батлан даалтын харьцаа**

Японы Санхүүгийн Корпорац (JFC) 1953 онд үүсгэн байгуулагдсанаас хойш зээлийн батлан даалтын хувь хэмжээ цаг хугацааны явцад өөрчлөгдөж, анх ЖДҮ-ийн зээлийн батлан даалтын хувь хэмжээг 100% гэж тогтоож байсан бол аажмаар бууруулж 2021 оны байдлаар 80% болжээ. Тухайлбал хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуурын салбарт зээлийн батлан даалтын хувь хэмжээг анх 100 хувь байхаар тогтоож байсан бол одоогоор 90% хүртэл бууруулжээ. Харин боловсролын салбарын зээлийн баталгааны хувь хэмжээ 1962 онд хэрэгжиж эхэлснээс хойш 100% хэвээр байна. 2021 оны байдлаар жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ)-ийн зээлийн баталгааны харьцаа 50 сая иен хүртэлх зээлийн хувьд 80%, 50 сая иенээс дээш зээлийн хувьд 70% байна. Харин хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуурын хувьд 30 сая иен хүртэлх зээлийн хувьд зээлийн баталгааны харьцаа 90%, 30 сая иенээс дээш бол 80% байгаа бол боловсролын хувьд 30 сая иен хүртэлх зээлийн хувьд 100%, 30 сая иенээс дээш бол 90% зээлийн баталгааны харьцаатай байна (Japan Finance Corporation (JFC)).

##### **Солонгосын зээлийн батлан даалтын харьцаа**

Зээлийн батлан даалтын тогтолцоог БНСУ-д 1976 онд анх ЖДҮ-ийг дэмжих зорилгоор нэвтрүүлж эхэлсэн бөгөөд батлан даалтын хувь хэмжээ жил ирэх тусам нэмэгдсээр байжээ. Тухайлбал, ЖДҮ-ийн зээлийн батлан даалтын хувь хэмжээг 1978 онд 50%-иас 60%, 1981 онд 70%, 1998 онд 80% болгон нэмэгдүүлсэн. Хамгийн сүүлд COVID-19 тахлын эсрэг Солонгосын засгийн газар баталгааны хувь хэмжээг түр хугацаагаар нэмэгдүүлжээ. Тухайлбал 2020 оны байдлаар Солонгосын засгийн газар болон Зээлийн батлан даалтын сан нь арилжааны банкнууд болон бусад санхүүгийн байгууллагуудаас жижиг, дунд үйлдвэрүүдэд олгосон зээлийн 70 хүртэлх хувьд баталгаа гаргаж байгаа бөгөөд Засгийн газар 50 хувь, KODIT 20 хувь тус тус батлан дааж байна.

##### **Малайзын зээлийн батлан даалтын харьцаа**

Дунджаас дээгүүр орлоготой Малайзын хувьд 2020 оны байдлаар Засгийн газар болон Зээлийн батлан даалтын корпораци нь ЖДҮ-ийн зээлийн 80 хүртэлх хувьд баталгаа гаргаж байна. Зээлийн батлан даалтын тогтолцоог Малайзад 1972 онд анх ЖДҮ эрхлэгчдэд зээл авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор зээлийн батлан даалтын корпораци

байгуулснаар нэвтрүүлсэн. Зээлийн батлан даалтын корпорацийн зээлийн баталгааны схем нь ЖДҮ-д зээл олгоходоо санхүүгийн байгууллагуудыг зээлийн эрсдэлээс хамгаалахыг чухалчилдаг бөгөөд энэ нь эргээд энэ салбарт илүү их зээл олгоход эерэг нөлөөтэй байдаг. Малайзын Засгийн газар 2019 онд ЖДҮ-ийн зээлийн баталгааны дээд хэмжээг 50-100 хувь болгон нэмэгдүүлсэн. Мөн ЖДҮ-ийг дэмжих зорилгоор зээлийн мэдээлэл, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, зээлийн хүсэлт, олголтыг шуурхай болгох дижитал платформыг хэрэгжүүлэх зэрэг олон шинэ арга механизмуудыг нэвтрүүлээд байна.

### **Шри-Ланкагийн зээлийн батлан даалтын харьцаа**

Шри-Ланка улсын Засгийн газар болон Зээлийн батлан даалтын корпорац нь ЖДҮ-ийн зээлд баталгаа гаргахдаа ЖДҮ-ийн ашигт ажиллагааг харгалзаж хамгийн их ашиг олох боломжтой ЖДҮ-г батлан дааж байна. Сонирхолтой нь уг улсад зээлийн баталгааны мэргэшсэн байгууллага байхгүй төдийгүй засгийн газар оролцдоггүй байна. Харин төв банк арилжааны банканд зээлийн баталгаа өгч байна. Шри-Ланка улс зээлийн батлан даалтын тогтолцоог 1967 онд ЖДҮ-ийг дэмжих зорилгоор төв банк нь анх нэвтрүүлсэн. Түүнээс хойш зээлийн батлан даалтын харьцаанд хэд хэдэн өөрчлөлт орсон ба тухайн ЖДҮ-ийн ашигт ажиллагаанаас хамааран зээлийн 50-80 хүртэлх хувьд баталгаа олгож байна. Мөн Шри-Ланка улсын Засгийн газар ЖДҮ-ийг дэмжих зорилгоор донор байгууллагуудын олон төрлийн хөтөлбөр, үйл ажиллагаа хэрэгжүүлсэн нь ЖДҮ-ийн салбарын өсөлтийг нэмэгдүүлжээ.


### **Филиппиний зээлийн батлан даалтын харьцаа**

Дундаас дээш орлоготой Филиппин улсын хувьд 2021 оны байдлаар Засгийн газар болон Зээлийн батлан даалтын корпораци нь ЖДҮ-ийн зээлийн баталгаа гаргаж байгаа бөгөөд зарим зээлийн баталгааны хөтөлбөрүүдийн хувьд зээлийн батлан даалтын дээд хувь хэмжээ 80 хувьд хүрчээ. Тухайн улсад зээлийн батлан даалтын тогтолцоо нь 2001 онд ЖДҮ эрхлэгчдийн зээлийг баталгаажуулан ЖДҮ-ийн өсөлтийг дэмжих зорилгоор зээлийн батлан даалтын корпорацийг байгуулснаар үүсжээ. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр зээлийн баталгааны хувь хэмжээ нэмэгдэж 2016 онд 70%-аас 80% болж өсжээ. Мөн засгийн газрын зүгээс бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд бага хүүтэй зээл олгох хөтөлбөрүүдийг дэмжиж байна.

### **Энэтхэгийн зээлийн батлан даалтын харьцаа**


Барьцаагүй зээлийг хөнгөвчлөх зорилгоор Энэтхэгийн Засгийн газар 2000 онд ЖДҮ эрхлэгчдэд зориулсан зээлийн батлан даалтын сан анх байгуулжээ. Бусад улсын адил ЖДҮ-ийн бизнес эрхлэгчдийг зорилтот үйлчлүүлэгч гэж үзсэн ба анх үүсэн байгуулагдсанаас хойш 2009 онд дэлхийн санхүүгийн хямралын дараа ЖДҮ-ийн өсөлтийг нэмэгдүүлэхээр зээлийн батлан даалтын дээд хувь хэмжээг 10 хувиар нэмэгдүүлэн 85 хувьд хүргэжээ. 2010 оны 3-р сарын байдлаар тус санд бүртгэлтэй 112 банк, байгууллага, корпорац, зээлийн байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна. Харин 2022 оны байдлаар Энэтхэг дэх бичил, жижиг бизнесийн (MSE) салбар нь 26 сая орчим аж ахуйн нэгжийг хамарч, ойролцоогоор 60 сая хүнийг ажлын байраар хангасан байна.

Зураг 4.13 Зээлийн батлан даалтын харьцаа, өндөр орлоготой улстай харьцуулахад




Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл, (ADB, 2022)

Зураг 4.14 Зээлийн батлан даалтын харьцаа, дундаас дээш орлоготой улстай харьцуулахад



Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл, (ADB, 2022)

Зураг 4.15 Зээлийн батлан даалтын харьцаа, дундаас доош орлоготой улстай харьцуулахад




Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл, (ADB, 2022)


Зээлийн батлан даалтын харьцааны харьцуулсан шинжилгээгээр өндөр орлоготой Япон, БНСУ, манай улстай орлогын түвшнээр нэг ангилалд буюу дундаас доош орлоготой ангилалд багтдаг Энэтхэг, Шри-Ланка, дундаас дээш орлоготой Малайз, Филиппин зэрэг улсуудын бичил, жижиг, дунд үйлдвэрүүдэд олгох зээлийн батлан даалтын харьцааны динамик өөрчлөлтийг харьцуулан судаллаа Зураг 4.14, Зураг 4.15-д харуулсанчлан дунд орлоготой орнуудын засгийн газар болон зээлийн батлан даалтын байгууллагууд нь анх үүсгэн байгуулагдсанаасаа хойш зээлийн батлан даалтын харьцааг өсгөж байсан нь харагдаж байна. Харин хөгжингүй буюу өндөр орлоготой Япон болон Солонгос улсуудын хувьд харгалзан 1950 болон 1970-аад оны үеэс эхлэн жижиг дунд үйлдвэрүүдэд зээлийн баталгаа гаргаж ирсэн ба эдийн засгийн уналт болон сэргэлттэй уялдуулан зээлийн баталгааны хувь хэмжээг өсгөх, бууруулах зохицуулалтыг хийж иржээ. Зураг 4.13-аас харахад Япон, БНСУ нь зээлийн баталгааны харьцаагаа 10 орчим жилийн мөчлөгтэйгөөр өсгөж, 2020 оны байдлаар зорилтот ЖДҮ-ийн бизнес болон зээлийн баталгааны эх үүсвэрээс шалтгаалан ЖДҮ-ийн зээлийн 50-аас 100 хүртэлх хувьд батлан даалт гаргаж байна.

Нэгтгэн дүгнэвэл олон улс, хөгжингүй орнуудын туршлагаас эдийн засаг томорч, хөгжихийн хэрээр ЗБДТ-ы ЖДҮ-д зориулсан бараа, үйлчилгээ төрөлжиж үүнд улс орнууд зээлийн батлан даалтын харьцааг нэмэгдүүлэх хандлага ажиглагдаж байна. ЗБДС нь анх үүсэхдээ хувийн секторын оролцоо чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд цаг хугацаа өнгөрөхийн хэрээр хөгжиж төрийн оролцоо давамгайлах хандлагатай болж байна. Нөгөө талаас ЗБДТ нь хувьсан хөгжиж зөвхөн хувь, эсвэл зөвхөн төрийн оролцоотой бус олон улсын донор байгууллага, хувь хөрөнгө оруулагч, бүс нутаг, орон нутгийн захиргаа, арилжааны банкууд хөрөнгө оруулах, өмчлөх, давхар батлан даах, эх үүсвэр олгох зэргээр оролцох боломжтой болсон. Манай улсын хувьд орон нутгийн захиргаа, хувь хөрөнгө оруулагчид албан бусаар ЖДҮ-г санхүүжүүлэх, дэмжих тогтолцоотой байна. Мөн одоогийн байгаа ЗБДТ нь 100 хувь төрийн хяналт, оролцоотой буюу төр 100 хувь өмчилж байгаа нь төр дангаараа ажлын байр, экспорт, эдийн засагт чухал нөлөө бүхий ЖДҮ-ийн өсөлтийг нэмэгдүүлэхэд хангалттай зохицуулалт хийж удирдаж чадахгүй зэрэг тогтолцооны дутмагшлыг бий болгож байна. Үүнд судлаачийн зүгээс дараах зээлийн батлан даалтын загварыг санал болгож байна.

Зураг 4.16 Одоогийн зээлийн батлан даалтын загвар



Зураг 4.17 Санал болгож буй зээлийн батлан даалтын загвар



Эх сурвалж: Судлаачийн хийсэн зураглал

Санал болгож буй загварт зээлийн батлан даалтын санг төрөлжүүлж, уг сангуудтай холбогдох оролцогчдын тодорхойлон үүсэж болох харилцааг нарийвчлан авч үзлээ. Загварт хэд хэдэн нэмэлт өөрчлөлтийг авч үзсэн ба тодруулбал өмчлөл, хөрөнгө оруулалт, эх үүсвэр, давхар батлан даалт гэсэн өөрчлөлтүүдийн ач холбогдлыг тодорхойлов. Үүнд:

1. Экспортод чиглэсэн үйл ажиллагаа бүхий ЖДҮ-ийн зээлийн батлан даалтын санг бий болгох шаардлагатай ба энэ нь ЖДҮ-ийн өсөлтийн түвшнийг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй. Манай улсад үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ-ийн 2 хүрэхгүй хувь нь экспортын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байна. Экспортод чиглэсэн ЗБДС-ийн эх үүсвэрийн хувьд төр болон донор байгууллага байх бол орон нутаг, төр давхар батлан даалт юм. Харин хувь хөрөнгө оруулагчид, болон арилжааны банкнууд ЗБДС-д хөрөнгө оруулснаар өмчлөл эрхтэй болох ба энэ нь зээлийн чанар, зээлийн зориулалтын дагуу ашиглах байдлыг нэмэгдүүлэх нөлөөтэй.
2. Тухайн салбарт чиглэсэн ЖДҮ-ийн зээлийн батлан даалтын санг бий болгох шаардлагатай. Давхар батлан даалт, өмчлөл болон хөрөнгө оруулалт, эх үүсвэрийн хувьд экспортод чиглэсэн ЖДҮ-ийн зээлийн батлан даалтын сантай адилхан бөгөөд ач холбогдлын хувьд ялгаатай. ЗБДС нь төрөлжсөн хөгжингүй орнуудад
  - Ажлын байрыг хамгийн их нэмэгдүүлэх салбарын ЖДҮ
  - Тухайн улсын урт хугацааны бодлого, стратегийн дагуу дэмжиж буй салбарын ЖДҮ
  - Эдийн засагт нөлөө бүхий салбарын ЖДҮ
  - Жендерийн ялгаатай байдлыг бууруулах зорилгоор эмэгтэйчүүдэд чиглэсэн ЖДҮ

- Бүс нутгийн хөгжлийг сайжруулах зорилгоор тухайн бүс нутгийн ЖДҮ-д зориулан зээлийн батлан даалтын тусгайлсан сан байгуулсан байна.

Монгол улсын хувьд эдийн засгийн бүсчлэлийн онцлогоос шалтгаалсан ЖДҮ болон эмэгтэйчүүдэд чиглэсэн ЖДҮ-ийн дэмжлэг, хөнгөлөлттэй зээл, хөтөлбөр тодорхой түвшинд хэрэгжиж байна. Харин ЖДҮ-ийн өсөлтийг хэмжих ажлын байр, стратеги, эдийн засагт чухал үүрэг бүхий салбаруудаа бодлого, ЗБДТ-ы хувьд хангалтгүй буюу адилхан дэмжиж байна. Үүнд ажлын байрыг ихээр нэмэгдүүлэх боломжтой, эдийн засагт чухал нөлөөтэй, стратегийн хувьд ач холбогдол бүхий салбаруудад ялгаатай бодлого, зээлийн баталгааны тусгайлсан дэмжлэгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Цаашилбал импортын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэлээр 100 хувь хангах, хүнсний аюулгүй байдлыг нэмэгдүүлэх зорилготойгоор хэрэгжиж буй “Хүнсний хувьсгал” хөдөлгөөний хүрээнд аж ахуйн нэгжүүдэд 440 орчим тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгоод байна. Үүнийг өргөтгөн барилгын материал, машин, түүний эд анги зэрэг импортод өндөр жин эзэлдэг бараа үйлчилгээг дотоодод үйлдвэрлэх үйл ажиллагааны чиглэл бүхий ЖДҮ бизнест олгох хөнгөлөлттэй зээлийг нэмэгдүүлэх, зээлийн баталгааны дэмжлэгийг нэмэгдүүлэх зүйтэй.

3. Арилжааны банк эдгээр ЗБДС-уудад хөрөнгө оруулж, өмчлөх нь хяналт болон зээлийн чанарт эергээр нөлөөлнө. Зээлийн батлан даалтын харьцааг хэт өндөр тогтоосноор дефолтын эрсдэлийг бий болгож байсан зарим жишээг дурдсан. Үүнд арилжааны банк ЗБДС-д хөрөнгө оруулснаар өмчлөх эрх үүсэх ба энэ нь ЖДҮ-ийн зээлийн чанар сайжрах, зээл зориулалтын дагуу ашиглах хөшүүрэг, хяналтыг нэмэгдүүлэх үр нөлөөтэй. Нөгөөтээгүүр арилжааны банк өмчлөлд оролцсоноор ЗБДС-д тавих хяналт сайжрах боломжтой.
4. Харин орон нутгийн захиргааны хувьд тухайн бүс нутагт ач холбогдол бүхий ЖДҮ-д давхар батлан даалт үзүүлэх нь зүйтэй. Энэ нь ЖДҮ-д зориулсан дэмжлэг туслалцааг албан хэлбэрт оруулж байгаа бөгөөд ЖДҮ-ийн нийт санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, тухайн орон нутгийн эдийн засагт чухал үүрэг бүхий ЖДҮ бизнес эрхлэгчдээ дэмжих хөшүүрэг болох гэх мэт олон талын ач холбогдолтой байна.
5. Олон улсын донор байгууллагын хувьд, өөрийн зорилт, чиглэлээс хамааруулан төрөлжсөн ЗБДС-д эх үүсвэр өгөх ба ЖДҮ-д олгогдох зээл зориулалтын дагуу зарцуулагдах суурь зохицуулалт болно.

Санал болгож буй загвар нь “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын “Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд:

- Бизнес инкубатор төвүүдийг байгуулах, тэдгээрийн хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлэх, үйл ажиллагааг дэмжих
- Жижиг, дунд үйлдвэрлэгчдийн хөгжлийг дэмжих институцийн тогтолцоог бүрдүүлж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох



- Жижиг, дунд үйлдвэрийн салбарт олгож буй төрийн болон олон улсын байгууллагын зээл, тусламжийн санхүүжилтийг үр ашигтай болгож, оролцогч талуудын уялдааг сайжруулах
- Санхүүжилтийн бусад эх үүсвэр, лизинг болон факторингийн талаарх ойлголт, хэрэглээг нэмэгдүүлэх, экспортын чиглэлийн үйлдвэр эрхлэгчдэд зориулсан батлан даалт, даатгалыг нэвтрүүлэх
- Гадаад орнуудад суугаа дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан жижиг, дунд үйлдвэрлэлд шаардлагатай технологийн инновацын талаарх мэдээлэл авах, олон улсын үзэсгэлэн, яармаг болон бизнес уулзалтууд зохион байгуулах замаар хөрөнгө оруулалтын түншлэлийг өргөжүүлнэ.
- Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтэц болон үйлдвэрлэлийн цогцолбор байгуулж, шинэ салбарыг хөгжүүлэх

гэсэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагаатай нийцтэй төдийгүй хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх ач холбогдолтой гэж үзэж байна.

## ДҮГНЭЛТ

Өндөр хөгжсөн болон хөгжиж буй бүхий л улс орнуудын хувьд жижиг, дунд үйлдвэр, гарааны бизнест зориулсан санхүүгийн үйлчилгээний хүртээмж нь эдийн засаг, нийгмийн хөгжлийнх нь томоохон асуудал болжээ. Энэхүү судалгааны ажлаар монгол улсын жижиг, дунд үйлдвэрийн салбарын санхүүжилтийн орчныг сайжруулах, санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд зээлийн батлан даалтын тогтолцооны гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх боломжийг олон улс, хөгжингүй орнуудтай харьцуулан судлалаа. Энэ хүрээнд ЖДҮ-ийн санхүүжилтэд тулгардаг саад бэрхшээлүүдийг тодорхойлж, тэдгээрийн шийдвэрлэх санхүүжилтийн арга хэрэгслүүд, өргөн ашиглагддаг загваруудыг шинжлэв.

Шинжилгээний үр дүнд ЖДҮ-ийн ажил эрхлэлтэд оруулж буй нөлөө сайн, эдийн засаг, экспортод оруулж буй нөлөө хангалтгүй ба ЖДҮ эрхлэгч аж ахуйн нэгжийн тоог өсгөх шаардлагатай байна. Инфляц, ажилгүйдэл, хээл хахууль, гадаад худалдаа хийх таагүй нөхцөл, газар эзэмших боломж муу, татварын буруу тогтолцоо, иргэдийн худалдан авах чадвар муу, зам, тээвэрлэлтийн нөхцөл муу, зээлийн барьцаа хөрөнгийн дутмаг байдал, буруу үнэлгээ, зээлийн хүү, шимтгэл өндөр, ур чадвартай хүний нөөцийн дутагдалтай байдал нь ЖДҮ-ийн өсөлтийг хамгийн их хязгаарлаж байна. ЖДҮ-ийн бизнес, санхүүжилтийн орчны асуудалд хөгжингүй болон хөгжиж буй орнууд зээлийн батлан даалтыг түгээмэл ашиглаж байгаа бөгөөд хугацааны турш зээлийн батлан даалтын харьцааг салбар, чиглэл, эх үүсвэрээс хамааруулан өсгөж ирсэн. Манай орны хувьд ЗБДТ нь бойжилтын үе шатандаа явж байгаа хэдий ч зээлийн баталгааны харьцааг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Ингэхдээ экспорт болон ажлын байрыг хамгийн их бий болгох, эдийн засагт оруулах нөлөө их, стратегийн хувьд дэмжих шаардлагатай ЖДҮ бизнест зээлийн баталгааны харьцааг нэмэгдүүлэх нь зүйтэй.

ЗБДС нь анх үүсэхдээ хувийн секторын оролцоо чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд цаг хугацаа өнгөрөхийн хэрээр хөгжиж төрийн оролцоо давамгайлах хандлагатай болж байна. Нөгөө талаас ЗБДТ нь хувьсан хөгжиж зөвхөн хувь, эсвэл зөвхөн төрийн оролцоотой бус олон улсын донор байгууллага, хувь хөрөнгө оруулагч, бүс нутаг, орон нутгийн захиргаа, арилжааны банкнууд хөрөнгө оруулах, өмчлөх, давхар батлан даах, эх үүсвэр олгох зэргээр оролцох боломжтой болсон. Манай улсын хувьд орон нутгийн захиргаа, хувь хөрөнгө оруулагчид албан бусаар ЖДҮ-г санхүүжүүлэх, дэмжих тогтолцоотой байна.

Үүнд судлаачийн зүгээс зээлийн батлан даалтын загварыг санал болгосон бөгөөд загварт зээлийн батлан даалтын санг төрөлжүүлж, уг сангуудтай холбогдох оролцогчдын тодорхойлон үүсэж болох харилцааг нарийвчлан авч үзсэн. Загварт хэд хэдэн нэмэлт өөрчлөлтийг авч үзсэн ба тодруулбал өмчлөл, хөрөнгө оруулалт, эх үүсвэр, давхар батлан даалт гэсэн өөрчлөлтүүдийн ач холбогдлыг тодорхойлов. Санал болгож буй загвар нь “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаатай нийцтэй байна. Судалгааны үр дүнд нэг болон хоёрдугаар таамаглал бүрэн гуравдугаар таамаглал хэсэгчлэн дэмжигдсэн.

## САНАЛ ЗӨВЛӨМЖ

Судалгааны дүгнэлтэд үндэслэн дараах санал, зөвлөмжийг боловсруулав.

- Засгийн газар, бодлого боловсруулагчид экспортыг нэмэгдүүлэх болон ажлын байрыг ихээр бий болгох боломжтой, эдийн засагт оруулах нөлөө их, стратегийн хувьд дэмжих шаардлагатай ЖДҮ бизнест зээлийн баталгааны харьцааг нэмэгдүүлэх нь зүйтэй. Мөн барилгын материал, машин, түүний эд анги зэрэг импортод өндөр жин эзэлдэг бараа үйлчилгээг дотоодод үйлдвэрлэх үйл ажиллагааны чиглэл бүхий ЖДҮ бизнест олгох хөнгөлттэй зээлийг нэмэгдүүлэх, зээлийн баталгааны дэмжлэгийг нэмэгдүүлэх хэрэгтэй.
- Судалгааны үр дүнд ЖДҮ эрлэгч бизнест зээлийн батлан даалтын харьцааг нэмэгдүүлэх шаардлагатайг тогтоосон. Цаашдын судалгаанд экспортод чиглэсэн, эдийн засаг, ажлын байрыг нэмэгдүүлэхэд нөлөө бүхий салбар болон бусад салбаруудад ЗБДХ-г тус бүр хэдэн хувиар нэмэгдүүлэх талаар нарийвчлан судлах, тооцоолох шаардлагатай.
- ЗБДТ нь 100 хувь төрийн хяналт, оролцоотой буюу төр 100 хувь өмчилж байгаа нь төр дангаараа ажлын байр, экспорт, эдийн засагт чухал нөлөө бүхий ЖДҮ-ийн өсөлтийг нэмэгдүүлэхэд хангалттай зохицуулалт хийж удирдаж чадахгүй зэрэг тогтолцооны дутмагшлыг бий болгож байгаа тул хувийн сектор (арилжааны банк, хувь хөрөнгө оруулагчид) өмчлөлд оролцох шаардлагатай.
- Олон улс болон хөгжингүй орнуудад бизнесийн орчны үнэлгээндээ хэд хэдэн орчны үнэлгээ түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг авч үздэг ба манай улсаас ялгаатай нь боловсрол, хүний нөөц болон удирдлагын ур чадвар гэсэн нөлөөлөгч хүчин зүйлсийг үнэлж байна. Үүнээс Монгол улс ЖДҮ-ийн бизнесийн орчны судалгаа, үнэлгээнд цаашид хүний нөөц, удирдлагын ур чадвар болон боловсролыг хамааруулан авч үзэх хэрэгтэй.

**НОМ ЗҮЙ****МОНГОЛ ХЭЛ ДЭЭР:**

- Б.Анужин. (2019). *Жижиг, дунд үйлдвэрийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломж, арга зам*. СЭЗИС: Улаанбаатар.
- Б.Оюунбилэг. (2022). *Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг сайжруулах замаар ждү эрхлэгчдийн санхүүжилтийг нэмэгдүүлэх*. Улаанбаатар: СЭЗИС.
- Б.Цэнгэл. (2020). *Жижиг дунд бизнесийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга зам*.
- Г.Цог-Өрнөх. (2001). *Жижиг дунд бизнес ба төрийн дэмжлэг*. Улаанбаатар.
- Жижиг, д. ү. (2023 оны 04 16). [www.sme.gov.mn](http://www.sme.gov.mn): <https://sme.gov.mn/faqs>
- М. Гэрэлтуяа. (2020). *Бичил болон ждү-ийн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх боломж, арга зам*. Улаанбаатар: СЭЗИС.
- Монгол банк. (2016). *Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал*. Улаанбаатар.
- Монгол банк. (2018). *Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал*. Улаанбаатар.
- Монгол банк. (2022). *Бизнесийн үйл ажиллагаа, санхүүжилтийн байдал*. Улаанбаатар.
- Н.Амарсайхан. (2016). *Жижиг дунд үйлдвэрийг венчур капиталын санхүүжилтээр дэмжих нь*. Улаанбаатар: СЭЗИС.
- Н.Сайнсанаа, С.Хандмаа, Б.Тэмүлүн. (2019). *Жижиг дунд үйлдвэрлэлийн тулгамдаж буй асуудлууд ба олон улсын туршилага*. Улаанбаатар: СЭЗИС.
- О.Алтаннавч. (2018). *Арилжааны банкуудын жижиг дунд үйлдвэрүүдэд олгох зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга зам*. Улаанбаатар: СЭЗИС.
- С.Гэрэлчимэг. (2018). *Жижиг дунд бизнес эрхлэгчдийн санхүүжилтийг шийдэх арга зам*. Улаанбаатар.
- Санхүүгийн зохицуулах хороо. (2021 оны 5). *Жижиг дунд үйлдвэрлэл ба түүний санхүүжилт: харьцуулсан судалгаа. Хүртээмжтэй санхүү, хууд. 16*.
- Үндэсний статистикийн хороо. (1995-2004). *Монгол Улсын Статистикийн эмхэтгэл*. Улаанбаатар: Адмон ХХК.
- Үндэсний статистикийн хороо. (2022). *Аж ахуй нэгжсийн тооллого-2021*. Улаанбаатар.
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам. (2020). *Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн гарын авлага*. Улаанбаатар.

Э.Ундрах-Эрдэнэ. (2019). *Арилжааны банкуудын жижиг дунд үйлдвэрүүдэд олгох зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга зам.*

Энхбайгаль, Б. (2014). *Кейсийн судалгаа: Гарын авлага.* Улаанбаатар: Сэлэнгэпресс.

#### ГАДААД ХЭЛ ДЭЭР:

Asian Development Bank. (2015). *Asia SME Finance Monitor 2014.* Manila: ADB.

Asian Development Bank. (2018). *The role of SMEs in Asia and their difficulties in accessing finance.* Tokyo.

Asian Development Bank. (2022). *Financing Small and Medium-Sized Enterprises in Asia and the Pacific, Credit Guarantee Schemes.* Manila.

Asian Development Bank. (2023). *Asia small and medium-sized enterprise monitor.* ADB.

Beck, T. L. (2008). *The Typology of Partial Credit Guarantee Funds around the World.* Washington.

Chatzouz, Moustafa; Gereben, Áron; Lang, Frank; Torfs, Wouter. (2017). *Credit Guarantee Schemes for SME lending in Western Europe.* Luxembourg: European Investment Fund (EIF).

Cheng, X. (2019). *Research on the Causes and Countermeasures of Financing Difficulties of Small and Medium-sized Enterprises.*

Dyllong, E. (2007). *A Multifunctional Historical Document Research System.*

E. Nistor, D.-R. P. (2013). *Romanian SMEs Financing Options: An Empirical Analysis.*

Félix Corredera-Catalán, F. d. (2021). *Post-COVID-19 SME financing constraints and the credit guarantee scheme solution in Spain.* Springer.

Glasner, D. (2021). *Studies in the History of Monetary Theory.*

Group, V. I. (2014). *Credit Guarantee Schemes for SME lending in Central, Eastern and South-Eastern Europe.* Luxembourg: European Investment Fund (EIF).

Guercio, M. Belen etc. (2020). *Credit Crunch or Loan Demand Shortage: What Is the Problem.* Czech Journal of Economics & Finance.

Guy Selbherr, A. G. (2009). *Organizations and Economic Benefits of German Guarantee Banks, Journal for SME development.*

Higgins & Green. (2008). *Cochrane Handbook for Systematic Reviews of Interventions.* John Wiley & Sons.

Ichiro Uesugi, K. S. (2006). *Effectiveness of Credit Guarantees in the Japanese Loan Market.*

- Jae Won Kang , Almas Heshmati. (2007). *Effect of credit guarantee policy on survival and performance of SMEs in Republic of Korea*. Seoul: Technology Strategy and Planning Division, Korea.
- Jae-Ha Park, Byung-Chul Lim, Jung-Han Koo. (2008). *Developing the Capital Market to Widen and Diversify SME Financing: The Korean Experience*.
- Kuwahara, S. N.-H. (2016). *Role of the Credit Risk Database in Developing SMEs in Japan: Ideas for Asia*. Tokyo.
- Levitsky, J. (2006). *Credit guarantee funds and mutual guarantee systems*.
- Linda Deelen, K. M. (2004). *Guarantee Funds for Small Enterprises*.
- Mankiw, N Gregory. (1989). *Real Business Cycles: A New Keynesian Perspective*. Journal of Economic Perspectives.
- Meghana Ayyagari, T. B.-K. (2014). *Small and Medium Enterprises across the Globe*. Springer.
- Mintrom, M. (2011). *Contemporary policy analysis*. Oxford University Press.
- Mr. J. M. Keynes. (1936). *General Theory of Employment, Interest and Money*.
- Mulazzani, M. (2004). *History and development of cassa depositi e prestiti*.
- Naoyuki Yoshino, F. T.-H. (2018). *Optimal Credit Guarantee Ratio for Small and Medium-Sized*.
- Pablo Gabriel Bortz. (2021). *Keynes's Theories of the Business Cycle: Evolution and Contemporary Relevance*. Levy Economics Institute of Bard college.
- R. K. GUPTA. (1968). *Hawthorne's Theory of Art*. Duke University Press.
- Shinozaki, S. (2012). *A New Regime of SME Finance in Emerging Asia*. Manila.
- UNDP. (1999). *Small and Medium Enterprise Development*.
- United Nations Economic and Social Commission for Asia and the Pacific. (2017). *Small and medium enterprises financing*.
- Valerie Smith, D. D. (2011). *Methodology in conducting a systematic review of systematic reviews of healthcare interventions*.
- World bank. (2022). *Mongolia business environment and competitiveness assessment report*. Washington: World bank group.
- Worldbank. (2012). *Financial sector assessment program development module*.
- Yamori, N. (2015). *Japanese SMEs and the credit guarantee system after the global financial crisis*.

## ХАВСРАЛТ

Хавсралт А.

ЖДҮ-ийн аж ахуйн нэгж, экспорт, бүтээгдэхүүнд эзлэх хувь

	Нийт аж ахуйн нэгжид эзлэх хувь (%)	Экспортод эзлэх хувь (%)	Гарцад эзлэх хувь (%)	Гарцын үзүүлэлт	Жил
<b>Өндөр орлоготой улсууд</b>					
Япон	99.7	...	43.7	Борлуулалт	2012
Солонгос	99.9	18.8	47.6	Нэмүү өртөг	2012
Сингапур	99.4	...	45.0	ДНБ	2012
<b>Дундаас дээш орлоготой улсууд</b>					
БНХАУ	97.3	41.5	60.0	ДНБ	2011, 2013,
Казахстан	96.1	...	23.1	ДНБ	2016
Малайз	97.3	...	35.9	ДНБ	2014
Филиппин	99.6	...	35.7	Нэмүү өртөг	2013, 2006
Тайланд	99.7	26.3	39.6	ДНБ	2014
<b>Дундаас доош орлоготой улсууд</b>					
Бангладеш	99.0	...	25.0	ДНБ	2014
Энэтхэг	...	42.4	37.5	Нэмүү өртөг	2013
Индонез	99.9	15.7	60.3	ДНБ	2013
Шри Ланка	99.5	20.0	30.0	ДНБ	2013
Узбекистан	...	26.5	56.9	ДНБ	2016
Вьетнам Нам	97.7	...	...		2012

Эх сурвалж: (Asian Development Bank, 2018)

## Хавсралт В.

## ЖДҮ-ийн ажиллагчдын тооны бүлэг, борлуулалтын орлогын бүлгээр


Ажиллагчдын тооны бүлэг	Борлуулалтын орлогын бүлэг	2017	2018	2019	2020	2021	2022
(1-9)	300.0 сая төгрөг хүртэл	40027	41433	42422	42883	43911	52455
	300.0 -999.9 сая төгрөг	2884	3511	4321	5051	6323	8357
	1.0-2.4 тэрбум төгрөг	837	957	1297	1543	2163	3042
(10-49)	300.0 сая төгрөг хүртэл	2442	2790	2721	2612	2322	2203
	300.0 -999.9 сая төгрөг	984	1541	1646	1711	1700	1750
	1.0-2.4 тэрбум төгрөг	542	1015	1139	1169	1381	1555
(50 - 199)	300.0 сая төгрөг хүртэл	143	91	114	85	66	66
	300.0 -999.9 сая төгрөг	83	57	46	35	33	24
	1.0-2.4 тэрбум төгрөг	137	109	104	141	116	87

Эх сурвалж: [Үндэсний статистикийн хороо](#)



Хавсралт С.

Судлагдсан байдлын оюуны зураглал



Эх сурвалж: Судлаачийн хийсэн зураглал

Хавсралт D.

Зээлийн батлан даалтын үзүүлэлтүүд, орлогын ялгаатай улсуудаар

Улс	Батлан даалтын харьяа байгууллага (Байгуулагдсан он)	Давхар батлан даалттай эсэх	Зорилтот бизнесийн бүлэг	Зохицуулагч (хянагч) байгууллага	Зээлийн баталгааны хувь (%)
Япон	JFC (2008)	Тийм	ЖДҮ	Засгийн газар, холбогдох байгууллага	–
	NFCGC (1953)	–	ЖДҮ		80-100
Солонгос	KODIT (1976)	Тийм	Бүх төрлийн бизнес	Засгийн газар, холбогдох байгууллага	50–85
	KOREG (2000)	–	ЖДҮ		85-100
	KOTEC (1989)	–	Техник чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч ЖДҮ		85
Малайз	CGCMB (1972)	–	ЖДҮ	Төв банк	50-100
Филиппин	SBC (2001)	–	ЖДҮ	Төв банк	70-80
Монгол	CGFM	–	ЖДҮ	Засгийн газар, холбогдох байгууллага	60
Энэтхэг	CGTMSE (2000)	–	ЖДҮ	Засгийн газар	50–85
Шри Ланка	Шри Ланкийн Төв банк (1967)	–	Ашигтай бизнесүүд	–	50-80

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл, (ADB, 2022)